



The Asia Foundation



УЛААНБААТАР ХОТЫН ЭЦЭГ, ЭХ БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН УНШИХ ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА

2022.06



ӨМНӨХ ҮГ

Лоринэт сан нь Монгол болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудын зорилтот бүлгийн бага насны хүүхэд багачууд, залуучуудын хөгжил боловсролыг дэмжих, тэдний амьдралд эерэг бөгөөд урт хугацааны тогтвортой үр нөлөөг бий болгохоор зорин ажилладаг гэр бүлийн сан юм.

Бид өнгөрсөн жилээс Азийн сантай хамтран “Хамтдаа Уншицгаая” төслийг Монгол Улсад хэрэгжүүлж эхэлсэн юм. “Хамтдаа Уншицгаая” нь ном унших дадлыг сурталчлан таниулах замаар бага насны хүүхдийн боловсролын нэгэн чухал хэрэглэгдэхүүн болгоход чиглэсэн, урт хугацаанд хэрэгжих санаачилга билээ. Энэхүү төсөл нь Лоринэт сангийн бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрийн зорилго болоод бага наснаасаа номонд дурлаж өссөн тус сангийн хамтран үүсгэн байгуулагч Болор Лоринэтийн “Хүүхэд бүр ном уншиж өсөөсэй, тэгвэл тэд ямар хүн болмоор байгаагаа, мөн өөрсдийн амьдрахыг хүсэж буй дэлхийн тухай мөрөөдөж чаддаг болно” гэсэн хүсэлтэй нягт уялдаж байгаа юм.

“Хамтдаа Уншицгаая” төсөл нь сургуулийн өмнөх боловсролын бага насны хүүхдүүдийн сургуульд суралцах бэлэн байдал хангалтгүй байгаа асуудал дээр тулгуурласан ба Азийн сангаас уг төслийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ зорьсон зорилт, үр нөлөөгөө бий болгох, түүнийгээ нарийвчлан хэмжихэд ихээхэн анхаарч байна. Энэ хүрээнд, төслийн үр нөлөөний үнэлгээг гаргахад нэн шаардлагатай тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийхэд Лоринэт сангаас дэмжлэг үзүүлж буйдаа сэтгэл хангалуун байна. Энэхүү суурь судалгааны хүрээнд 0-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгдөг эсэх, уг дадлын ач холбогдлын талаарх ойлголт, хүүхдийн номын олдоц, хангамж зэргийг судалсан ба төслийн цаашдын зорилтын үр дүнд хүрэхэд чухал алхам болоод байна.

“Хамтдаа Уншицгаая” төсөл нь сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдийн сургуульд суралцах бэлэн байдал хангалтгүй байгаа асуудал дээр тулгуурласан ба Азийн сангаас уг төслийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ зорьсон зорилт, үр нөлөөгөө бий болгох, түүнийгээ нарийвчлан хэмжихэд ихээхэн анхаарч байна. Энэ хүрээнд, төслийн үр нөлөөний үнэлгээг гаргахад нэн шаардлагатай тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийхэд Лоринэт сангаас дэмжлэг үзүүлж буйдаа сэтгэл хангалуун байна. Энэхүү суурь судалгааны хүрээнд 0-5 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгдөг эсэх, уг дадлын ач холбогдлын талаарх ойлголт, хүүхдийн номын олдоц, хангамж зэргийг судалсан ба төслийн цаашдын зорилтын үр дүнд хүрэхэд чухал алхам болоод байна.

Болор болон Пьер Лоринэт

2022 оны 6 дугаар сар

Let's Read гар утасны аппликэйшн

"Let's Read" digital library for all children

Explore the world with your children through reading hundreds of high-quality books from "Let's Read" library.


Download
Let's Read app:



www.letsreadasia.org



Free to read online and offline,
and print from any device.



ТАЛАРХАЛ

Энэхүү суурь судалгааг IRIM судалгааны хүрээлэн Азийн сангийн захиалгаар 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 3 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэв.

IRIM судалгааны хүрээлэнгийн төслийн баг нь Азийн сангийн Суурин төлөөлөгч ноён Марк Кэйниг болон олон улсын зөвлөх хатагтай Катлин Кампана нарт судалгааны хэрэглэгдэхүүнийг эцэслэхэд техникийн болон арга зүйн зөвлөмж өгсөнд гүнээ талархал илэрхийлье. Мөн Азийн сангийн хөтөлбөрийн мэргэжилтэн Б.Халиун, төслийн ажилтан Г.Халиун нарт төслийг амжилттай хэрэгжүүлэхэд маш ойр харилцаа холбоотой ажилласанд нь талархаж байна.

Түүнчлэн боловсролын салбарын дараах эксперт, мэргэжилтнүүдэд сургуулийн өмнөх насны хүүхдэд ном унших соёлыг бий болгохтой холбоотой бодлогын өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгсөнд нь талархал илэрхийлье. Үүнд:

- Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн агуулга, чанар хариуцсан ахлах мэргэжилтэн Ц. Сарантуяа;
- Боловсрол, шинжлэх ухааны яамны Хүүхдийн хөгжил, тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвсайхан;
- Боловсролын ерөнхий газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Ж.Шинэбаяр;
- Боловсролын хүрээлэнгийн Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн судалгаа хариуцсан мэргэжилтэн Г. Монголхатан;
- Нийслэлийн боловсролын газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн З.Болормаа.

Эцэст нь, судалгааны багийн зүгээс судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдэд хүүхдэдээ ном унших зуршил, өөрсдийн номонд дуртай байдал, түүний ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт болон хүүхдийн номын хүртээмж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааныхаа талаар илэн далангүй мэдээлэл өгсөнд талархаж байна.

Судалгааны багийн гишүүд:

- Ш.Цэрэннадмид, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх;
- Г.Долгорсүрэн, IRIM судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач;
- Р.Цэдэн-Иш, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, зохицуулагч;
- Б.Шинэцэцэг, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач;
- А.Очбадрал, IRIM судалгааны хүрээлэнгийн дата менежер

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	2
ТАЛАРХАЛ	4
ХУРААНГУЙ	10

1. ТАНИЛЦУУЛГА **14**

1.1. Үндэслэл.....	15
1.2. Суурь судалгааны зорилго	15

2. СУДАЛГААНЫ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ **16**

2.1. Судалгааны дизайн.....	17
2.2. Түүврийн загвар, хэмжээ	17
2.3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	18
2.4. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	20
2.5. Судалгааны хязгаарлагдмал тал.....	23

3. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХҮҮХДЭДЭЭ НОМ УНШИЖ ӨГДӨГ БАЙДАЛ БОЛОН НОМОНД ДУРТАЙ БАЙДАЛ **24**

3.1. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг давтамж, хугацаа.....	25
3.2. Эцэг эхчүүд хүүхдээ номтой танилцуулах арга барилууд	28
3.3. Эцэг эхчүүд болон хүүхдүүдийн номонд дуртай байдал	33
3.4. Ном унших зуршлыг бий болгоход тулгарч буй бэрхшээлүүд.....	36

4. ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД, ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, МЕНЕЖЕРҮҮДИЙН ХҮҮХДЭД НОМ УНШИЖ ӨГӨХИЙН АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ **39**

4.1. Хүүхдэд ном уншиж өгөх, тэднийг номонд дуртай болгохын ач холбогдол.....	40
4.2. Бага насанд нь хүүхдэд ном уншиж өгөх ба хүүхдийн хөгжилд үзүүлэх нөлөө, ач холбогдол	46
4.3. 1 болон 2 дугаар ангийн хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт.....	50

5. ХҮҮХДИЙН НОМЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ БОЛОН СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДЭД НОМ УНШИЖ ӨГӨХИЙГ ДЭМЖСЭН БОДЛОГЫН ОРЧИН **53**

5.1. Гэрт болон цэцэрлэг дээрх хүүхдэд зориулсан номын хүртээмжтэй байдал болон бэлэн байдал.....	54
5.2. Сургуулийн өмнөх насны хүүхдэд ном уншиж өгөхийг дэмжсэн бодлого, эрх зүйн орчин.....	57
5.3. Номын дэлгүүр, номын сан, нийтийн ном унших төвүүдийн хүртээмжтэй байдал	61

6. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ САЙН ТУРШЛАГА, НИЙТЛЭГ СОРИЛТУУД	64
6.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	65
6.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж буй сайн туршлагууд, сорилтууд	66
6.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйлчилгээнээс хоцорч буй хүүхдүүдэд тухайн орон нутгийн захиргааны байгууллагаас болон боловсролын байгууллагаас хүрч буй байдал	67
7. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	70
ХАВСРАЛТ	73

Зураг, хүснэгтийн жагсаалт

Зураг 1. Судалгааны дизайн	17
Зураг 2. Судалгаанд оролцогчид, дүүргээр	19
Зураг 3. Насны бүтэц, %	21
Зураг 4. Гэрлэлтийн байдал, %	21
Зураг 5. Боловсролын түвшин, %	22
Зураг 6. Өрхийн орлого, %	22
Зураг 7. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг давтамж зорилтот, зорилтот бус хороогоор	25
Зураг 8. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, боловсролоор	26
Зураг 9. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, зорилтот, зорилтот бус хороогоор	26
Зураг 10. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, өрхийн орлогын түвшингээр	27
Зураг 11. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг хугацаа, минутаар	27
Зураг 12. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг үе, зорилтот, зорилтот бус хороогоор	28
Зураг 13. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг арга барил	28
Зураг 14. Ном уншиж өгөхдөө хүүхдээсээ сэтгэхүйг нь ажиллуулах асуулт асуудаг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор	29
Зураг 15. Номонд дуртай болгох тоглоом хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор	30
Зураг 16. Номонд дуртай болгох тоглоом хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүд, өрхийн орлогоор	30
Зураг 17. Номонд дуртай болгох тоглоомоор хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүдийн хувь, эцэг эхийн хүйсээр, насаар	31
Зураг 18. Хүүхдэдээ ном уншиж өгөхдөө сэтгэл хөдлөлөө илэрхийллийг дэмждэг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор	31
Зураг 19. Хүүхдэд унших чадвар, зуршил суулгах бусад үйл ажиллагааг хийж буй эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор	32
Зураг 20. Хүүхдийг номонд дуртай болгох бусад үйл ажиллагааг хийж буй эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор	32
Зураг 21. Эцэг эхчүүдийн ном унших сонирхол, зорилтот, зорилтот бус хороогоор	33
Зураг 22. Хүүхдийн ном унших сонирхол, зорилтот, зорилтот бус хороогоор	33
Зураг 23. Хүүхдийн номонд дуртай шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор	34
Зураг 24. Ном уншиж өгөх үед хүүхдийн сонирхдог зүйл, зорилтот, зорилтот бус хороогоор	34
Зураг 25. Хүүхэд ном уншиж буй дүр эсгэдэг эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор	35
Зураг 26. Хүүхэд нь гадуур явахдаа самбарын тэмдэглэгээ сонирхдог эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор	35
Зураг 27. Ном уншиж өгөх үед хүүхэд нь бүрэн анхаардаг эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор	35
Зураг 28. Хүүхдийн номонд дургүй шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор	36
Зураг 29. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөггүй шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор	37
Зураг 30. Завгүй учраас ном уншиж өгдөггүй эцэг эхчүүд, өрхийн орлого, төгрөгөөр	37
Зураг 31. Эцэг эхчүүдийн хүүхдийг номтой танилцуулахад тохиромжтой гэж үзэж буй нас	40
Зураг 32. Эцэг эхчүүдийн хүүхдийг номтой танилцуулахад тохиромжтой гэж үзэж буй нас	41

Зураг 33. Хүүхдээ унших сонирхолтой болгох нь маш чухал гэж үздэг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор.....	41
Зураг 34. Эцэг эхчүүд хүүхдээ ном унших нь сонирхолтой зүйл гэдгийг ойлгуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүдийн, зорилтот, зорилтот бус хороогоор.....	41
Зураг 35. Хүүхдээ ном унших сонирхолтой болгох нь чухал гэж үзэж буй эцэг эхчүүд, боловсролоор.....	42
Зураг 36. Эцэг, эхчүүд гэртээ ном сайн уншуулдаг учраас тэд сургууль дээрээ сайнуншдаг гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор	43
Зураг 37. Эцэг, эхчүүд гэртээ ном сайн уншуулдаг учраас тэд сургууль дээрээ сайн уншдаг гэж үздэг эцэг эхчүүд, эцэг эхийн насаар	43
Зураг 38. Эцэг эхчүүд хүүхдэдээ унших, бичих чадварыг эзэмшүүлэх үүрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоо.....	43
Зураг 39. Эцэг эхчүүд хүүхдэдээ унших, бичих чадварыг эзэмшүүлэх үүрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор.....	44
Зураг 40. Үеэр тасалж унших хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд эцэг эх туслах ёстой гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор	44
Зураг 41. Өөрийн санаа бодлыг цаасан дээр зургаар илэрхийлэх хүсэл, сонирхолтой байх, өөртөө итгэлтэй болоход туслах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор.....	44
Зураг 42. Сургууль дээр заасан тоолох, уншиж бичих дасгал, даалгаврыг эцэг, эхчүүд гэрт нь давуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор..	45
Зураг 43. Сургууль дээр заасан тоолох, уншиж бичих дасгал, даалгаврыг эцэг, эхчүүд гэрт нь давуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор	45
Зураг 44. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор	46
Зураг 45. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, хүйсээр.....	46
Зураг 46. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь нийгэмшихүйн хөгжилд нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор.....	47
Зураг 47. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь сургуульд амжилттай сурахад нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор.....	47
Зураг 48. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь сургуульд амжилттай сурахад нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор.....	48
Зураг 49. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойр дотноболно гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор	48
Зураг 50. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойр дотноболно гэж үздэг эцэг эхчүүд, хүйсээр	48
Зураг 51. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь хэл ярианы хөгжил нь сайжирна гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор.....	49
Зураг 52. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь хэл ярианы хөгжил нь сайжирна гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор.....	49
Зураг 53. Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор	50
Зураг 54. Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан эсэх, хүйсээр	50
Зураг 55. Нэг болон хоёрдугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулахын өмнө ном уншиж өгөхийн чухлыг хэрхэн харж байгаа эсэх.....	51
Зураг 56. Судалгаанд оролцсон өрхүүдийн номын санд буй номын тоо, зорилтот болон зорилтот бус хороогоор, зорилтот, зорилтот бус хороогоор	54
Зураг 57. Судалгаанд оролцогчдын гэрт буй хүүхдэд зориулсан номын тоо, зорилтот, зорилтот бус хороогоор	55
Зураг 58. Судалгаанд оролцогчдын хүүхдэдээ зориулж ном худалдаж авахдаа ач	

холбогдол өгдөг зүйлс, эрэмбээр	55
Зураг 59. Судалгаанд оролцогчид хүүхдэдээ ном худалдан авахад тулгардаг нийтлэг бэрхшээлүүд, зорилтот ба зорилтот бус хороогоор.....	56
Зураг 60. Уншдаг номын хэлбэр ба илүүд үздэг номын хэлбэр , зорилтот ба зорилтот бус хороогоор.....	57
Зураг 61. Гэрээсээ хамгийн ойр номын сан ороход зарцуулж буй хугацаа, минутаар	61
Зураг 62. Эцэг эхчүүдийн бодлоор хүүхэд нь номтой хамгийн ойр байдаг газар, зорилтот, зорилтот бус хороогоор	62

Хүснэгт 1. Төслийн үр дүнг хэмжих гол үзүүлэлтүүд, суурь судалгааны үр дүнгээр.....	13
Хүснэгт 2. Тоон болон чанарын судалгааны түүврийн хуваарилалт.....	18
Хүснэгт 3. Судалгааны аналитик хүрээний агуулга.....	19
Хүснэгт 4. Эцэг эхийн хүүхдээ бага насанд нь номтой танилцуулах ач холбогдол ба тэдний унших дадал хоорондын хамаарал.....	51
Хүснэгт 5. СӨБ-ын талаар хэрэгжиж буй гол эрх зүй, бодлогын баримт бичгүүд.....	57



ХУРААНГУЙ

Хүүхдэд бага наснаас эхлэн ном уншиж өгөх нь түүний аливаа зүйлийг ойлгох чадвар болон бусадтай харилцах харилцааг сайжруулдгийг олон судалгааны үр дүн харуулж байна. Түүнчлэн хүүхдийн сониуч байдал, анхаарал төвлөрөл, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл нийгэмшихүйн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хувь хүн болж төлөвшихөд эергээр нөлөөлдөг.

Азийн сан нь “Хамтдаа уншицгаая” төслийг Лоринэт сангийн дэмжлэгтэйгээр 2021 оны долоодугаар сараас эхлэн эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчид хүүхдэдээ тогтмол ном уншиж өгөх, боловсролын үр дүнг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэхүү төсөл нь Монгол хэл дээрх хүүхдийн чанартай номын хүртээмжийг нэмэгдүүлэх, насанд хүрэгчдэд бага насны хүүхдэдээ ном унших хэвшлийг бий болгоход чиглэсэн арван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн эхний гурван жилийн төсөл юм. Уг төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн нь Азийн сангийн захиалгаар 0-5 настай хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын ном унших дадал, хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын тухай мэдлэг, ойлголт, мөн гэр болон цэцэрлэгт буй хүүхдэд зориулсан номын хүртээмжийн талаарх мэдээлэл цуглуулах суурь судалгааны ажлыг 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 03 дугаар сарын хооронд хэрэгжүүллээ.

ГОЛ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөх зуршил болон номонд дуртай байдал

- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөх, түүнийг номонд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагаа хязгаарлагдмал байна. Тодруулбал, зорилтот хорооны эцэг эхчүүдийн 23.6% нь, зорилтот бус хорооны эцэг эхчүүдийн 20.7% нь хүүхдэдээ ном огт уншиж өгдөггүй гэж хариулсан. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн ердөө 9.7% нь хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг байна. Нэг удаад хүүхдэдээ ном уншиж өгөх хугацаа дунджаар 10 минут үргэлжилдэг байна.
- Хүүхдэдээ ном уншиж өгөх, түүнийг номонд дуртай болгох үйл ажиллагаа нь эцэг эхчүүдийн боловсролын түвшинтэй шууд хамааралтай байна. Эцэг эхийн боловсролын түвшин доогуур байх тусам хүүхдэдээ ном уншиж өгөх нь бага байна. Сонирхолтой нь, өрхийн орлого өндөр байх тусам эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхөд зарцуулж буй цаг бага байна. Орлогын эх үүсвэрээ тасалдуулахгүйн тулд ажил ихтэй байдаг учир хүүхдэдээ бага цаг зарцуулдаг гэж тайлбарлажээ.
- Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөхдөө интерактив аргыг ашиглах нь бага байна. Харин хүүхдэд ном уншиж өгөх явцад хүүхдийн илэрхийлэх сэтгэл хөдлөлийг хүлээн авч зөвшөөрөх нь илүү сайн байна. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 4.3%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 16.8% нь хүүхдэдээ ном уншиж өгөхдөө сэтгэн бодох чадварыг шалгасан асуулт асуудаг гэжээ. Харин хүүхдийн сэтгэл хөдлөлийг 'байнга', 'ихэвчлэн' хүлээж авах, зөвшөөрөх байдал зорилтот хороодод 64.3%, зорилтот бус хороодод 61.4% байна.
- Эцэг эхчүүд завгүй ажилладаг, хүүхдэдээ ном авч өгөх санхүүгийн бололцоо муу, гэрийн ойролцоо номын сан, дэлгүүр байхгүй байгаа зэрэг шалтгаан нь ном уншиж өгөх соёл дэлгэрэхгүй байх нөхцөл болж байна.

Хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын тухай эцэг эхчүүдийн ойлголт, мэдлэг

- Ихэнх эцэг эхчүүд хүүхдээ номонд дуртай болгох нь чухал гэдэгтэй санал нийлж байна. Тодруулбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн 95.2% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 96.8% нь хүүхдээ номонд дуртай болгох нь чухал гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна.
- Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд олон эерэг нөлөө үзүүлдэг гэдэгтэй санал нийлж байна. Судалгаанд эцэг эхчүүд хүүхдэд ном уншиж өгөх нь тэдний танин мэдэхүйн хөгжил, сурлагын амжилт зэрэгт эергээр нөлөөлдөг гэж үзэж байна. Харин, хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд үзүүлэх нөлөөнд эцэг эхчүүд хамгийн бага ач холбогдол өгдөг нь судалгааны үр дүнгээс харагдсан. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн 78.7%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 73.1% нь хүүхдэдээ ном уншиж өгөх нь түүний танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэдэгтэй 'бүрэн' санал нийлсэн байна. Харин хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэдэгтэй 'бүрэн' санал нийлсэн эцэг эхчүүдийн хувь зорилтот хороодод 66.3%, зорилтот бус хороодод 61% байна.
- Эцэг эхчүүдийн 41.9% нь хүүхдээ номтой танилцуулах, ном уншиж өгч эхлэхэд хамгийн тохиромжтой насыг 3-5 нас гэж үзсэн бол 39% нь 3 наснаас өмнө уг үйлийг хийх хэрэгтэй гэж үзсэн.
- Зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх буюу 40.4% нь хүүхдийг 3-5 насанд нь номтой танилцуулах нь тохиромжтой гэж үзсэн бол зорилтот хорооны хувьд энэ үзүүлэлт 47.3% байна. 0-2 насанд танилцуулах нь тохиромжтой гэж зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 39% нь үзсэн бол энэ насыг сонгосон зорилтот хорооны

эцэг эхчүүд 33%-ыг эзэлж байна.

- 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн маш бага хувь нь хүүхдээ сургуульд элсэхээс өмнө ном уншиж өгч байсан гэж хариулжээ. Тодруулбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 10.9% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 8.8% нь хүүхдэдээ 'байнга' ном уншиж өгдөг байсан гэж хариулжээ. Энэ үзүүлэлтийг хүйсийн хувьд харьцуулж үзвэл ээж нар (11.6%) аавуудыг (0%) бодвол хүүхдэдээ ном уншиж өгөх нь илүү байна.
- 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдэдээ ном унших өгөх нь харьцангуй бага байсан хэдий ч ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлдгийг ойлгож байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 64% нь ном унших нь хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэхэд 'маш чухал' гэж үзсэн бол хэл ярианы хөгжил (59%), анхаарлаа төвлөрүүлэх чадварт (56%) нь 'маш чухал' нөлөөтэй гэж үзсэн. Харин хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд үзүүлэх нөлөөнд эцэг эхчүүд (40%) хамгийн бага ач холбогдол өгч буй нь судалгааны үр дүнгээс харагдсан.

Хүүхдийн номын хүртээмж ба сургуулийн өмнөх насны хүүхдэд ном уншиж өгөхийг дэмжихтэй холбоотой бодлого, эрх зүйн орчин, туршлагауд

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан ном цэцэрлэг болон гэрийн орчинд тодорхой хэмжээнд байна. Тухайлбал, эцэг эхийн боловсролын түвшин өндөр байх тусам гэрт нь хүүхдийн ном олон байна. Харин, санхүүгийн боломжгүй гэсэн шалтгаанаар маш олон өрх хүүхдэдээ ном авч өгдөггүй байна. Номын хүртээмжтэй байдлыг тодруулахад гэртээ 20-оос дээш номтой өрх зорилтот хороонд 35.7%, зорилтот бус хороонд 47.9% байна. Харин 1-5 номтой айл зорилтот хороонд 14.8%, зорилтот бус хороонд 24.7% байна.
- Судалгаанд хамрагдсан хороодод нийтийн номын сан, номын дэлгүүрийн хүртээмж хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн 51.8% нь гэрийнх нь ойролцоо ямар ч номын сан байхгүй гэж хариулсан. Харин 21.5% нь гэртэй нь ойр номын дэлгүүр байдаг гэжээ. Эцэг, эхчүүдийн ердөө 10% нь хамгийн ойр номын сан ороход ойролцоогоор 15-30 минут зарцуулдаг гэж хариулжээ.
- Судалгаанд оролцогчид хүүхдэдээ зориулж ном худалдан авахдаа насных нь онцлогт тохирсон байхыг (зорилтот хороонд (81.9%), зорилтот бус хороонд (74.1%)) чухал үзэж байна. Түүнчлэн ном худалдаж авахдаа хүүхдийн сонирхолд нийцсэн, бичвэр багатай, зураг ихтэй байхыг илүүд үздэг бол үнэ боломжийн байхыг (зорилтот хороонд 22.5%, зорилтот бус хороонд 20.3%) илүүд үзэж байна.
- Боловсролын байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас дүгнэхэд Монгол хэл дээрх хүүхдийн номонд тавих нэгдсэн шалгуур, стандартыг шинэчлэн батлах шаардлага байна.
- Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн багш, менежерүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс том хүний тусламжгүйгээр хүүхэд хүрэхүйц газар номыг байрлуулах хэрэгтэй гэсэн ойлголттой байгаа нь ажиглагдсан. Судалгааны үр дүнгээс харвал хүүхдүүд насанд хүрэгчдийн тусламжгүйгээр ихэвчлэн гэртээ номтой хамгийн ойр (зорилтот хороо 62.1%, зорилтот бус хороонд 79.7%) байна. Цэцэрлэг болон хүүхэд харах үйлчилгээний төвд (зорилтот хороо 34.5%, зорилтот бус хороонд 17.4%) хүүхдүүд номтой хамгийн ойр байна.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд эцэг, эхчүүд нь цахим ном уншиж өгөх соёл хэвшээгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн хариултаас харахад цахим хэлбэрийн ном худалдан авч уншдаг гэр бүл зорилтот хороонд 18.1%, зорилтот бус хороонд 10.8% байна. Үлдсэн хэсэг нь цахим номыг сонирхохгүй байна.

Харин зарим цэцэрлэг өөрийн веб хуудсандаа цахим ном байршуулж эхэлсэн нь хэвлэмэл ном худалдаж авах боломжгүй өрхүүдэд хүүхдүүдэд ном уншиж өгөх, гэрийн даалгаврыг нь хийлгэхэд туслах ач холбогдолтой байна.

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхдэд хүргэхэд чиглэсэн хэд хэдэн эрх зүйн болон бодлогын баримт бичиг хэрэгжиж байна. Эдгээр баримт бичигт сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох талаар онцгойлон дурдсан зүйл заалт нарийвчлан тусгаагүй байна. Гэсэн хэдий ч, цэцэрлэгүүд хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зорилгынхоо хүрээнд номтой танилцуулах, номонд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.
- Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, боловсролын байгууллагын хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгож, ашиг тусыг нь цохон тэмдэглэж байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулахад гэр бүл болон цэцэрлэгт тулгарч буй нийтлэг асуудлууд (Чанарын судалгааны мэдээлэлд голчлон үндэслэв)

- Цэцэрлэгүүд ном ашиглан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг өөрсдийн хязгаарлагдмал төсөвтөө тааруулан зохион байгуулдаг ч номын хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна.
- Бага насны хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эх, асран хамгаалагчид болон цэцэрлэг, орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж буй сайн жишээ, туршлагууд байна.
- Цэцэрлэгийн багш нар хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эхийн оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой олон үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих, эцэг эх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах үйл ажиллагааг цэцэрлэгүүд тогтмол зохион байгуулж байгаа ч улсын хэмжээний нэгдсэн бодлого зохицуулалт хязгаарлагдмал байна.
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнээс хоцорсон, эсвэл, хоцрох эрсдэлтэй хүүхдүүдэд уг үйлчилгээг хүргэхэд орон нутгийн захиргааны болон боловсролын байгууллагууд анхаарч, холбогдох төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчидтэй хамтран ажилладаг ч хүртээмж, хамрагдалт харьцангуй бага байна. Үүний гол шалтгаан нь түр оршин суугчид буюу харьяаллын асуудалтай иргэдийн аж амьдрал байна.

Хүснэгт 1.Төслийн үр дүнг хэмжих гол үзүүлэлтүүд, суурь судалгааны үр дүнгээр

Индикатор	Суурь судалгаа		Эцсийн судалгаа
	Нийт	Зорилтот хороо	
Ном унших сонирхолтой гэж хариулсан 0-5 насны хүүхдийн хувь	51.6	15.9	TDB
0-5 насны хүүхдэд ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголттой эцэг эхчүүдийн хувь	73	73.6	TDB
Хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг эцэг эхчүүдийн хувь	9.7	7.1	TDB
Хүүхдэдээ долоо хоногт 1-2 удаа ном уншиж өгдөг эцэг эхчүүдийн хувь	37.8	32.4	TDB
Гэртээ 3-с дээш номтой 0-5 насны хүүхдийн хувь	74.1	74.7	TDB

A woman and a young girl are standing in a field of tall grass, looking at a tablet together. The woman is wearing a dark blue long-sleeved shirt and the girl is wearing a dark blue dress with a white unicorn design. The background is a soft-focus landscape with trees and hills under a warm, golden light. The entire image has a semi-transparent pink overlay.

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Үндэслэл

Азийн сангаас “Хамтдаа уншицгаая” төслийг хүүхдүүддээ ном уншиж өгөхийн ач холбогдлыг сурталчлах, сургуулийн өмнөх боловсролын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны долоодугаар сараас Монгол Улсад хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэхүү санаачилга нь монгол хэл дээрх хүүхдийн номын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, насанд хүрэгчид бага насны хүүхэдтэйгээ хамт ном унших хэвшлийг бий болгоход чиглэсэн цогц хөтөлбөр юм. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчид номыг бага насны хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал “хэрэгсэл” болгон ашиглахад туслах зорилготой юм.

Бага наснаас нь эхлэн хүүхдэд ном уншиж өгөх нь хүүхдийн танин мэдэхүй болон харилцах чадвар эрс сайжирдгийг олон судалгаа нотолсоор байна. Түүнчлэн хүүхэд бага наснаасаа номтой танилцаж, нөхөрлөхөд хувь хүний зан чанар, сониуч зан, анхаарал төвлөрөлт, оюун ухаан нь хөгждөг төдийгүй сэтгэл хөдлөлөө удирдах, нийгэм хамт олны дунд биеэ авч явах, харилцааны соёлтой болох зэрэгт эерэг нөлөө үзүүлдэг байна.

Монгол Улсад 2-4 насны хүүхдүүдийн дөнгөж 58% нь насанд хүрэгчдийн анхаарал халамж дор суралцдаг байна. Бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын түвшин доогуур ба бага насны хөгжлийг дэмжих хүртээмж хангалтгүй үзүүлэлттэй байна. Сургуулийн өмнөх насны Монгол хүүхдийн бие бялдар, сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн хөгжил дутмаг байгаа бөгөөд 3-4 насны хүүхдүүдийн дөнгөж 8.5% нь бичиг үсэг, тоо бодох чадварын стандартыг хангаж байна. Түүнчлэн Монгол Улсын бага насны хүүхдийн хөгжлийн индекс 2010 оноос хойш тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд сургах, хөгжүүлэх эцэг эхийн дадал, соёл хангалтгүй байгааг тоо баримт харуулж байна¹.

“Хамтдаа уншицгаая” төслийн хүрээнд [Азийн сангийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн](#) нь 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 03 дугаар сарын хооронд Суурь судалгааны ажлыг гүйцэтгэв.

1.2. Суурь судалгааны зорилго

IRIM судалгааны хүрээлэн нь суурь мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгдөг зуршил², хүүхдийг номтой танилцуулах, ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт³, гэр, сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдэд зориулсан номын хүртээмж⁴, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа⁵ ямар түвшинд байгааг тодруулсан. Суурь судалгааны мэдээллийг “Хамтдаа уншицгаая” төслийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан өөрчлөлт, үр дүнг хэмжихэд хэрэглэнэ.

1 ҮСХ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018

2 Энэхүү судалгаанд ‘унших зуршил’ гэдэг эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөх дадал туршлагыг, хүүхдүүдийн үсэг, тоо нүдэлсэн байдлыг илэрхийлнэ.

3 Энэхүү судалгаанд ‘ном уншиж өгөх ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэг’ гэдэг нь эцэг эхчүүд хүүхдэдээ бага насанд нь ном уншиж өгөхийн ач холбогдлын талаар ойлгож буй эсэхийг илэрхийлнэ.

4 Энэхүү судалгаанд ‘номын хүртээмжтэй байдал’ гэдэг нь гэрт болон цэцэрлэгт хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном байгаа эсэх болон хүүхэд насанд хүрсэн хүний тусламжгүйгээр номонд хүрэх боломжтой газар байрлуулсан илэрхийлнэ.


5 Энэхүү судалгаанд ‘бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа’ гэдэгт эцэг эх, асран хамгаалагчид, цэцэрлэгийн багш нарын хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох зорилготой хийж буй бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгоно.

A close-up photograph of a person's hand writing in a notebook. The image is overlaid with a semi-transparent purple filter. The text is centered on the page.

2. СУДАЛГААНЫ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

2.1. Судалгааны дизайн

Зураг 1. Судалгааны дизайн



Тайлбар: A1 нь зорилтот бүлгийн суурь судалгааны үр дүн, A2 нь зорилтот бүлгийн эцсийн шатны үнэлгээний үр дүн. X нь энэхүү төслийн гол үр дүн. Төслийн эцсийн үр дүн интервенц нь X-ээр хэмжигдэнэ.

Судалгааны энэ загвар нь суурь судалгааг хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц, давтагдах боломжтой болгож өгнө.

Хяналт, үнэлгээ: “Хамтдаа уншицгаая” төслийн суурь судалгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээний аргаар харьцуулах боломжтой байна. Иймд суурь судалгааны үр дүнг явцын болон эцсийн шатны үнэлгээтэй харьцуулах боломжтой арга ашиглан гаргана.

Байршил: Түүврийн хэмжээ нь төслийн зорилтот байршлуудын зорилтот бүлгийг төлөөлөхүйц байна.

Цаг хугацаа: Судалгааны үр дүнгийн гол үзүүлэлтүүдийг цаг хугацааны хувьд харьцуулах боломжтой байна. “Өмнөх ба дараах судалгааны загвар” нь нэг хувьсагчийн суурь үр дүнг тодорхой хугацааны дараа буюу төсөл хэрэгжиж дуусмагц харьцуулалт хийх, судалгааны түлхүүр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, хэлбэлзлийг тодорхойлоход тусална.

2.2. Түүврийн загвар, хэмжээ

Судалгааны ажлын даалгаварт дурдсанчлан судалгааны түүврийн хүрээг Улаанбаатар хотод амьдардаг нийт 0-5 насны хүүхдийн тоогоор бүрдүүлсэн. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2020 онд Улаанбаатар хотод 0-5 хүртэлх насны 180 мянга орчим хүүхэд байна. Түүврийн хэмжээг тооцоходоо дараах тэгшитгэлийн дагуу тооцсон.

- n = Түүврийн хэмжээ,
- z = Хүсч буй ач холбогдлын утгыг тодорхойлсон статистик утга
- p = Судалгааны түлхүүр үзүүлэлтийн хувийн жин
- c = Алдааны хязгаар
- z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.9
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин төсөөллөөр 0.5 байхаар таамаглав.

Таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авдаг бөгөөд энэ судалгаанд $\pm 3.39\%$ байв.

Тоон судалгааны түүврийн тухайд бүх дүүргээс төлөөлөл болгож, гэр хороолол, хотын төв, гэр хороолол орон сууц хосолсон байдлаар хороонуудыг сонгож авсан. Тоон судалгаанд сонгогдсон хороо, дүүргийн 834 эцэг, эх, асран хамгаалагчид оролцсон.

Харин чанарын судалгааны түүврийн тухайд зорилтот бүлэгтэй хамааралтай салбарын голлох төлөөллүүдийг хамруулж, нийтдээ 50 гүнзгийрүүлсэн ярилцлага хийж мэдээллийг боловсруулсан.

Хүснэгт 2 . Тоон болон чанарын судалгааны түүврийн хуваарилалт

ТООН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР			ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР	
Дүүрэг	Хороо #	Түүврийн хэмжээ	Оролцогч талууд	n
Сонгинохайрхан	31, 43, 14	190	Боловсрол, шинжлэх ухааны яам	1
Баянзүрх	28, 5, 14	206	Нийслэлийн боловсролын газар	1
Чингэлтэй	14, 4	80	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	1
Баянгол	21, 17	129	Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтнүүд	9
Сүхбаатар	20, 2	74	Хорооны Засаг дарга, Нийгмийн ажилтан	8
Хан-Уул	2, 21	118	Цэцэрлэгийн эрхлэгч, аргазүйч	15
Налайх	1-8	37	Цэцэрлэгийн багш	6
Нийт		834	Бага ангийн багш	9
			Нийт	50

2.3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Энэхүү суурь судалгааны мэдээлэл цуглуулалтыг хийхдээ тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан. Үүнд асуулга, гүнзгийрүүлсэн ярилцлага, баримт бичгийн шинжилгээ багтана.

Судалгаагаар зорилтот болон зорилтот бус хорооны 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдээс судалгаа авсан. КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тоон судалгааны 20%-ийг онлайн мэдээлэл цуглуулалтын программын тусламжтайгаар зайнаас цуглуулсан. Мэдээлэл цуглуулалтад шаардлагатай 0-5 настай хүүхдүүдийн эцэг эхийн жагсаалтыг сонгогдсон хороо, дүүргийн цэцэрлэгүүдээс бүрдүүлсэн. Мэдээлэл цуглуулалт хийдээ дараах шалгуурыг баримталсан. Үүнд:

- 0-5 насны хүүхэдтэй эцэг, эх асран хамгаалагч байх;
- Судалгаанд сонгогдсон 0-5 насны хүүхдүүдийг нас, хүйсийн хувьд тэнцвэртэй байлгах;
- Талбарт мэдээлэл цуглуулахдаа 2 алхамт хийж, оролцогчдыг сонгох.

Цуглуулсан мэдээллийг өгөгдлийг боловсруулахдаа судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцож, нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц программ SPSS 26.0 (Statistical Package for the Social Sciences)-г ашигласан.

Индекс үзүүлэлтийг тооцохдоо тухайн үзүүлэлт хангагдсан үед 1, хангагдаагүй үед 0 гэсэн утга өгч тооцсон ба үзүүлэлт тус бүр тэнцүү жинтэй байхаар тооцсон. Тухайн судалгаанд оролцогч үзүүлэлтийг бүгдийг нь хангаж байвал тухайн оролцогчийн номын хүрэлцээ 1-тэй тэнцүү байх ба бүгдийг нь хангаж чадахгүй бол 0-тэй тэнцүү байна. Дараах тэгшитгэлд индексийн дэлгэрэнгүйг харууллаа.

$$c_i = W_1 I_1 + W_2 I_2 + \dots + W_d I_d$$

Чанарын судалгааны боловсруулалтыг хийхдээ MAXQDA программыг ашигласан.

Хүснэгт 3. Судалгааны аналитик хүрээний агуулга


Судалгааны зорилго, хамрах хүрээ	Үзүүлэлтүүд
Унших дадал, зуршил	1.1 Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгдөг давтамж 1.2 Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгдөг хугацаа 1.3 Хүүхдэдээ ном уншиж өгөхдөө ашигладаг арга, үйл ажиллагаа 1.4 Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдэдээ номын дэлгүүр, номын сан, олон нийтийн төвөөр зочилж номтой танилцуулдаг эсэх 1.5 Хүүхдэдээ ном уншиж өгөхөд тулгардаг бэрхшээлүүд Унших дадал зуршлыг дээр харуулсан үзүүлэлтүүдээр хэмжих ба эдгээр үзүүлэлтийг хүн ам зүй болон нийгэм эдийн шинж байдлаар нь харьцуулан шинжилгээ хийнэ.
Ном унших сонирхол, дуртай байдал	2.1 Хүүхдүүдийн номыг сонирхох, шалтгаан 2.2. Эцэг эхчүүдийн ном унших сонирхол, дадал зуршил
Хүүхдэд ном уншихын ач тусын талаарх эцэг эхчүүдийн ойлголт	3.1 Хүүхдэд номыг таниулах, номонд дуртай болгох нь чухал гэдгийг ойлгосон эсэх 3.2 Номыг хүүхдэдээ танилцуулж эхлэх тохиромжтой үе 3.3 Хүүхдэдээ ном уншиж өгөх, үлгэр ярьж өгөх, уншсан номынхоо талаар хүүхэдтэй ярилцах ашиг тусын талаар ойлгосон эсэх 3.4 Хүүхдэдээ ном уншиж өгөх үеийн сэтгэл хөдлөлийг дэмждэг эсэх 3.5 Эцэг эхчүүдийн хүүхдэд номтой танилцуулах талаарх ойлголт 3.6 Хүүхдэд багаас нь номтой танилцуулах талаарх эцэг эхчүүдийн санал бодол Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг эцэг эхийн хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдол, унших дуртай байдлын талаарх мэдлэгийг судлахдаа ашиглана.
Номын хүрэлцээтэй	4.1 Гэрт байгаа хүүхдийн номын тоо 4.2 Гэрт байгаа насанд хүрэгчдийн номын тоо 4.3 Цэцэрлэг дэх хүүхдийн номын хүртээмж 4.4 Гэр дэх хүүхдийн номын хүртээмж 4.5 Гэрт байгаа номыг хүүхэд бие даан үзэж, танилцах боломжтой эсэх 4.5 Өрхийн ном авахад зарцуулж буй төсөв 4.6 Хүүхдийн ном худалдаж авахад анхаарах гол зүйлүүд ба саад бэрхшээл 4.7 Хүүхдийн номын сан, номын дэлгүүр, нийтийн номын төвд хандах боломжууд 4.8 Цахим номын хэрэглээ 4.9 Дижитал болон хэвлэмэл номын талаарх эцэг эхчүүдийн ойлголт Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг номыг хүртээмжтэй байдлыг хэмжихэд ашиглана.

Судалгааны зорилго, хамрах хүрээ	Үзүүлэлтүүд
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	5.1. Хүүхдийг номтой танилцуулах үйл ажиллагаа ба давтамж 5.2. Эцэг эхчүүдийн хүүхдийнхээ эргэн тойронд ном унших дадал, зуршил 5.3. Эцэг эхчүүд ном уншиж өгөх үедээ хүүхэдтэйгээ хамтдаа үг үсэх нэрлэх, тоо тоолох, зураг зааж ярилцдаг эсэх 5.4. Номонд дуртай болгох тоглоомоор хүүхэдтэйгээ тоглодог эсэх Дээр дурдсан хэмжигдэхүүнүүдийг бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэмжих, түүнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлоход ашиглана.

2.4. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээллийг байршил, нас, хүйс, гэрлэлт, боловсролын түвшин, өрхийн сарын орлого зэрэг үзүүлэлтүүдийн хувьд авч үзлээ. Байршлын хувьд Улаанбаатар хотын 7 дүүргийн нийт 838 өрх хамрагдсан байна. Үүнээс 21.7% буюу 182 өрх зорилтот хороодоос хамрагджээ. Оролцогчдын тархалтыг дүүрэг тус бүрээр хоёрдугаар зурагт харуулав.

Зураг 2. Судалгаанд оролцогчид, дүүргээр




Хүйсийн хувьд нийт судалгаанд оролцогчдын 23.3% нь эрэгтэй, 76.4% нь эмэгтэй байна. Насны бүтцийн хувьд 26-с дээш насны оролцогч түүврийн 66.5%-г бүрдүүлж байна. (Зураг 3). Түүнчлэн судалгаанд оролцогчдын дундаж нас 34 бөгөөд хамгийн багадаа 16 настай, хамгийн ихдээ 75 настай хүмүүс оролцжээ. Судалгаанд хамрагдсан оролцогчдын 91.5% нь гэрлэсэн (Зураг 6) бөгөөд эрэгтэйчүүдийн 90.4% нь, эмэгтэйчүүдийн 91.7% нь тус тус гэрлэсэн байна.

Зураг 3. Насны бүтэц, %



Зураг 4. Гэрлэлтийн байдал, %



Судалгаанд оролцогчдын 84.6% нь хүүхдийн эцэг эх, 8.9% нь өвөө эмээ, 6.4% нь ах эгч нь байна. Эцэг эхчүүдийн 69% нь дээд боловсролтой, 22% нь бүрэн дунд боловсролтой, 5% техник ба тусгай мэргэжлийн, 2% нь суурь боловсролтой байна (Зураг 5). Гэр бүлийн гишүүдийн 51.2% нь бакалаврын боловсролтой байна.


Давхардсан дүнгээр оролцогчдын 1.4% нь өрх толгойлсон эцэг эх, 2.3%-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын өрхийн сарын дундаж орлого 1,500,000 төгрөг байсан ба 6.3% нь 500,000 төгрөгөөс бага орлоготой байгаа бол 20.8% нь 2.1 саяас дээш орлоготой байна.

Үндэсний статистикийн хорооны 2021 оны IV улирлын байдлаар өрхийн сарын дундаж орлого нийслэлийн хэмжээнд 1,642,915⁶ төгрөг байгаа бөгөөд энэ нь оролцогчдын өрхийн дундаж орлогоос 142,915 төгрөгөөр буюу 9%-иар их байна.


Өрхийн орлогын хүрэлцээг судалж үзэхэд 59.4% нь ойр зуурын хэрэгцээнд л хүрдэг гэж хариулсан. Судалгаанд хамрагдсан өрхийн ердөө 12.4% нь өрхийн орлогоосоо хуримтлал үүсгэж чаддаг бол үлдсэн нь хуримтлал үүсгэж чаддаггүй гэж хариулжээ.

6 ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, өрхийн сарын дундаж орлого, 2021

Зураг 5. Боловсролын түвшин, %



Зураг 6. Өрхийн орлого, %




Судалгаанд оролцогчдыг сууцны төрлөөр нь авч үзвэл зорилтот хороодын иргэдийн 87.4% нь гэрт амьдарч байгаа бол зорилтот бус хороодын хувьд энэ үзүүлэлт 40.5%-тай байна. Ам бүлийн гишүүдээр авч үзвэл оролцогчдын гуравны нэг нь (30%) зургаа ба түүнээс дээш гишүүнтэй байна. Судалгаанд сонгогдсон хүүхдүүдийн 53.1% нь эмэгтэй, 46.9% нь эрэгтэй байна. Насны бүтцийн хувьд:

- 1 хүртэл настай, 8.5%;
- 1 настай, 14.6%;
- 2 настай, 16.1%;
- 3 настай, 16.1%;
- 4 настай, 20.0%.

2.5. Судалгааны хязгаарлагдмал тал

Судалгааны мэдээлэл зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байгаа тул судалгааны үр дүн ч зөвхөн нийслэлийн 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн нөхцөл байдлыг илтгэнэ. Судалгааны үеэр Монгол Улсын хэмжээнд КОВИД-19 цар тахлын эсрэг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа түр хугацаанд хаагдсан. Үүний үр дүнд мэдээлэл цуглуулалтад дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Судалгааны мэдээлэл цуглуулалтын 20 хувийг утсаар авсан. Дээр дурдсан шалтгааны улмаас чанарын мэдээлэл цуглуулалтыг мөн адил онлайнаар хийсэн.
- КОВИД-19 цар тахал нэмэгдэж байгаатай холбоотой Монгол Улсын Засгийн газраас зарим сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Иймд судалгаанд оролцогчийн хүсэлтээр судалгааг өрхийн эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэг, өрхийн аль алинд нь мэдээлэл цуглуулалтыг хийсэн.
- 2020-2022 оны хичээлийн жилд Монгол Улсын Засгийн газраас 3-5 хүртэлх насны хүүхдүүдийг цэцэрлэгт авах шийдвэр гарсантай холбоотойгоор сонгогдсон цэцэрлэгүүд зөвхөн 3-5 насны хүүхдүүдийн жагсаалтыг гаргах боломжтой байсан. Иймд 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн жагсаалтыг харьяа дүүргийн засаг захиргааны нэгж болон өрхийн эрүүл мэндийн төвөөс авсан.

A young child with blonde hair is sitting and reading a book. The child is wearing a light-colored shirt with a red and green pattern. The background is a soft, out-of-focus indoor setting. A large, semi-transparent green overlay covers the entire image, and white text is centered on it.

3. ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХҮҮХДЭДЭЭ НОМ УНШИЖ ӨГДӨГ БАЙДАЛ БОЛОН НОМОНД ДУРТАЙ БАЙДАЛ


Тайлангийн энэ бүлэгт эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгдөг зуршил, тэдний номонд дуртай байдлын талаар хураангуйлан бичив. Тодруулбал, эцэг эх нь хүүхдэдээ хэр давтамжтай ном уншиж өгдөг, ямар арга барилаар ном уншиж өгдөг, хүүхдээ номонд дуртай болоход ямар дэмжлэг үзүүлдэг болон хүүхдэдээ ном унших өгөхөд эцэг, эхчүүдэд тулгардаг нийтлэг бэрхшээлүүдийг энд дурдсан болно.

3.1. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг давтамж, хугацаа

Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх дадал нь хүүхдийн хөгжилд цаашлаад тэднийг номонд дуртай болоход чухал үүрэг гүйцэтгэдэг⁷. Судалгаанд оролцогчид (цаашид эцэг, эхчүүд гэдэгтэй сөөлжиж хэрэглэгдэнэ.) -ын хүүхдэдээ ном уншиж өгөх зуршлыг 17 үзүүлэлтээр харахад нийт 1 оноо авахаас 0.4 оноо авсан. Үүнээс үзвэл эцэг эхчүүдийн дунд хүүхдэдээ ном уншиж өгөх зуршил, тэднийг номонд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байгаа нь харагдаж байна.

Судалгааны үзүүлэлтээс зорилтот хорооны 23.6% нь, зорилтот бус хорооны 20.7%-ийн эцэг эхчүүд хүүхдэдээ ном тогтмол уншиж өгдөггүй нь харагдаж байна. Эдгээр эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 36.8% нь бага боловсролтой байсан.

Зураг 7. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг давтамж зорилтот, зорилтот бус хороогоор




Ном уншиж өгөхөөс гадна хүүхдэдээ үлгэр, тууж ярьж өгөх нь бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чухал үйл ажиллагааны нэгд тооцогддог. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн ойролцоогоор 1/10 буюу 10.1% нь хүүхдүүддээ өдөр бүр үлгэр, тууж ярьж өгч чаддаггүй гэжээ. Харин 37.2% нь 7 хоногт нэгээс хоёр удаа, 27.6% нь сардаа нэгээс хоёр удаа, 25.1% нь огт уншиж өгдөггүй гэж хариулжээ. Тогтмол ном уншиж өгдөг эцэг эхчүүдийн хувь зорилтот ба зорилтот бус хороодод ойролцоо буюу тус бүр 9.9%, 10.2% байсан (Зураг 8).

Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүдийн боловсролын түвшин ба тэдний хүүхдэдээ үлгэр, тууж ярьж өгдөг хувийн хооронд ач холбогдолтой хамаарал байсан. Өөрөөр хэлбэл, бага боловсролтой эцэг эхчүүдийн ердөө 7%, бүрэн дунд, техник мэргэжлийн боловсролтой (25.1%), дээд боловсролтой (10.12%) нь өдөр бүр ном уншиж өгч байна.

7 Terms of Reference, Let's read Mongolia project.


Харин хүүхдэдээ үлгэр, тууж ярьж өгдөггүй эцэг эхчүүдийн дийлэнхийг буюу 69.1%-ийг бага болон дунд боловсролтой эцэг эхчүүд бүрдүүлж байна.

Зураг 8. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, боловсролоор




Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүдийн нас залуу байх тусмаа хүүхдэдээ ном уншиж өгөхөд зарцуулдаг хугацаа бусад насны бүлгийн эцэг эхчүүдтэй харьцуулахад бага байна. Жишээлбэл, 21-25 настай эцэг эхчүүдийн ердөө 8.9% нь хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг бол 46-50 настай эцэг эхчүүдийн 17% нь хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг байна. Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгдөг байдал өрхийн орлогын түвшингээс хамааран харилцан адилгүй байна. Өөрөөр хэлбэл, өрхийн орлого бага байх тусмаа өөрсдтөө төдийгүй хүүхдэдээ ном унших өгөх байдал бага байна. Харин өрхийн орлого өндөр байх тусмаа хүүхдэдээ ном уншиж өгөх байдал илүү өндөр байна.

Зураг 9. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, зорилтот, зорилтот бус хороогоор




Хүүхдийн хөгжлийг дэмжих өөр нэг үйл ажиллагаа бол тэднийг сонсох, янз бүрийн сэдвийн хүрээнд харилцан яриа өрнүүлэх явдал байдаг. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 70 гаруй хувь нь хүүхдээ анхааралтай сонсож, ярилцахад өдөр бүр цаг гаргадаг гэж хариулжээ. Харин эцэг эхчүүдийн 6.1% нь хүүхдэдээ дээрх цагийг гаргаж чаддаггүй байна. Эцэг эхчүүдийн боловсролын түвшингээс хамаарсан статистик ач холбогдолтой ялгаа энд харагдаагүй. Өрхийн орлогын хувьд сарын 1.5 саяас дээш орлоготой эцэг эхчүүдийн 54.9% нь мөн л хүүхдүүдээ анхааралтай сонсох, тэдэнтэй ярилцах цагийг гаргаж чаддаггүй байна. Үлдсэн 45.1% нь сарын 1.5 саяас бага орлоготой өрхийн эцэг эхчүүд байна. Өөрөөр хэлбэл, өрхийн орлого өндөр байх тусмаа эцэг эхчүүд хүүхдүүддээ зарцуулах цаг бага байна.

Зураг 10. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үлгэр ярьж өгдөг давтамж, өрхийн орлогын түвшингээр




Арваннэгдүгээр зурагт үзүүлсэнчлэн өрхийн орлого болон боловсролын түвшингээс хамааран эцэг эхчүүд хүүхдэдээ нэг удаад ном уншиж өгөхөд зарцуулж буй хугацаа харилцан адилгүй байна. Эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 39.5% нь хүүхдэдээ нэг удаа ном уншиж өгөхдөө 10-20 минут, 20-30 минут (26.9%), 10 хүртэлх минут (26.1%), 30-аас дээш минут (7.6%) зарцуулж байна. Бага насны хүүхдийн анхаарал төвлөрөх дундаж хугацаа ойролцоогоор 2-14 минут байдаг⁸. Иймд судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхдөө зарцуулдаг хугацаа нь тохиромжтой байгааг судалгааны өгөгдөл харуулж байна. Энэ хувь зорилтот хороодод дунджаар 10 минут, зорилтот бус хороодод 10-20 минут байсан. Энэ үзүүлэлтийг эцэг эхийн боловсролын түвшингээс хамаарч байгаа эсэхийг шалгахад статистик ач холбогдолтой ялгаа байгаагүй.

Зураг 11. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг хугацаа, минутаар



Эцэг эхчүүд ямар үед хүүхдэдээ ном уншиж өгч байгааг тодруулахад тэдний ихэнх нь буюу 48.6% нь завтай үедээ л хүүхдэдээ ном уншиж өгөх цаг гаргадаг гэж хариулжээ. Харин эцэг эхчүүдийн 44.9% нь унтахаасаа өмнө, хүүхэд өөрөө хүсэх үед (43.6%), шинэ ном худалдаж авсны дараа (39.2%), шаардлага гарвал гэж 11.5% нь хариулсан. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн дийлэнх буюу 61.9% зөвхөн зав гарсан үедээ хүүхдэдээ ном уншиж өгдөг гэсэн бол зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх (47.1%) унтахаасаа өмнө хүүхдэдээ ном унших цаг гаргадаг байна. Үүнээс эцэг эхчүүд хүүхдэдээ ном унших тогтмол цаг гаргаж, төлөвлөдөггүй нь харагдаж байна.


Зураг 12. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг үе, зорилтот, зорилтот бус хороогоор



3.2. Эцэг эхчүүд хүүхдээ номтой танилцуулах арга барилууг

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ ном уншиж өгөх, үлгэр тууж ярихдаа түүний сонирхол, анхаарлыг татах олон янзын аргыг ашиглаж байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн ихэнх нь буюу 42.1% нь нүүрний хувирал, дуу хоолойныхоо өнгийг өөрчлөх байдлаар хүүхдийнхээ анхаарлыг татаж, сонирхлыг төрүүлдэг бол 39.5% нь зураг, үсэг зэргийг гараараа заах, үлгэрт гарч буй дүрүүдийн дүрд хувирч, тэднийг дуурайх (38.4%), хүүхэдтэйгээ зохиолын талаар ярилцах (36.6%), дагуулж уншуулах аргыг 23.5% нь ашиглаж байна.


Зураг 13. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөг арга барил,%



Хүүхдийн хөгжлөөс шалтгаалан гурав хүртэлх настай хүүхдүүдийн эцэг эхчүүдийн 33.3% нь ихэвчлэн нүүрний хувирлаа өөрчилж байгаа бол 33.4% нь зохиолын дүрд тоглож хүүхдийнхээ сонирхол, анхаарлыг татаж байна. Эцэг эхчүүд хүүхдүүдээ ном уншиж өгөх, тэднийг номонд дуртай болгох нь хүүхдэд үлгэр, тууж ярьж өгөхөөс илүү сургамжтай байна. Гурваас таван настай хүүхдийн эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 79.4% нь ном уншиж өгөхдөө номын үг, үсэг, тоог гараар нь заалгаж байна. Ингэснээр хүүхдийн бага ангид элсэх бэлтгэл хангагдаж, тоо, үсэгтэй танил болно гэж үзэж байна. Ийнхүү хариулсан эцэг эхчүүдийн боловсролын түвшин, өрхийн орлогыг энэ үзүүлэлтийн үр дүнтэй хамааралтай эсэхийг шалгахад онцын ялгаа ажиглагдсангүй.

Эцэг эхчүүд өдөр бүр, эсвэл, долоо хоногтоо нэгээс хоёр удаа хүүхдэдээ ном уншиж өгвөл хүүхэд номонд дуртай болох магадлал илүү байдгийг судалгаагаар тогтоосон байдаг⁹. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон цэцэрлэгийн багш нар хүүхдүүддээ ном уншиж өгөхдөө тэднээс асуулт асууж, бодуулж сэтгүүлэх үйлдэл хийлгэдэг хэмээн ярьж байв. Түүнчлэн эцэг эхчүүд уншиж өгсөн ном, зохиолынхоо талаар хүүхэдтэйгээ хэрхэн ярилцах, асуулт асуух талаар зөвлөгөө өгдөг байна. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 16.8% нь хүүхдээ номонд дуртай болгохдоо интерактив аргыг ашиглаж байна (Зураг 14).


Зураг 14. Ном уншиж өгөхдөө хүүхдээсээ сэтгэхүйг нь ажиллуулах асуулт асуудаг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор



Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүд хүүхдээ номонд дуртай болгох олон төрлийн арга хэрэглэх тохиолдол бага байна. Жишээлбэл, зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 19.7% нь хүүхдүүдтэйгээ ном уншиж өгөхдөө түүнтэй холбоотой тоглоом 'байнга' and 'ихэвчлэн' тоглодог гэж хариулсан бол энэ хувь зорилтот бус хороонд 24.6% байв (Зураг 15). Эсрэгээрээ, зорилтот хороодын эцэг эхчүүдийн 39.5% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн and 42.5% иймэрхүү үйл ажиллагаа хүүхэдтэйгээ хийдэггүй гэж хариулжээ.


9 Children's and Young People's Reading Habits and Preferences, Christina Clark and Amelia Foster National Literacy Trust, 2005.

Зураг 15. Номонд дуртай болгох тоглоом хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор




Энэ үзүүлэлтийг өрхийн орлогоор нь харьцуулж харвал, сарын 300,000-500,000 төгрөгийн орлоготой эцэг эхчүүдийн 4.7% нь хүүхдээ номонд дуртай болгох олон төрлийн арга хэрэглэдэг бол 500,000-700,000 төгрөгийн орлоготой эцэг эхчүүдийн 5.7%, 900,000-аас 1.3 сая төгрөг (22.7%), 1.3 сая төгрөгөөс дээш орлоготой эцэг эхчүүдийн 60.3% нь хүүхэдтэйгээ ном уншихад ашиглах тоглоом, тэднийг номонд дуртай болгох үйлдлийг хийж байна. Үүнээс харвал илүү өндөр орлоготой эцэг эхчүүд энэ төрлийн үйлдэлд илүү анхаарч, ач холбогдол өгдөг хандлага байна.

Зураг 16. Номонд дуртай болгох тоглоом хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүд, өрхийн орлогоор



Дээрх үйл ажиллагаа буюу хүүхэдтэйгээ ном уншихтай холбоотой тоглоом 'хэзээ ч тоглодоггүй' гэсэн эцэг эхчүүдийн хувь 'байнга тоглодог', 'ихэвчлэн тоглодог' гэж хариулсан эцэг эхчүүдийн хувиас илүү өндөр байсан. Үүнийг эцэг эхчүүдийн насны бүлгээр авч үзвэл 20-оос доош насны эцэг эхчүүдийн 2.8% нь 'байнга тоглодог', 'ихэвчлэн тоглодог' гэж хариулжээ. Харин 21-30 насны эцэг эхчүүдийн 28.3%, 31-40 насны эцэг эхчүүдийн 35%, 40-өөс дээш настай эцэг эхчүүдийн 33.9% нь хүүхэдтэйгээ ном уншихтай холбоотой тоглоом тоглодог гэж хариулжээ. Энэ үзүүлэлтийг хүйсийн хувьд харьцуулж үзвэл аавуудаас илүү ээжүүд хүүхэдтэйгээ ийм төрлийн тоглоом тоглож байгаа нь ажиглагдлаа.

Зураг 17. Номонд дуртай болгох тоглоомоор хүүхэдтэйгээ тоглодог эцэг эхчүүдийн хувь, эцэг эхийн хүйсээр, насаар



Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн багш нар, удирдлагуудын ярианаас дүгнэж үзэхэд эцэг эхчүүд хүүхдийнхээ хэл яриа, унших чадварыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, тодорхой цаг зарцуулах хандлага нэмэгдэж байгааг онцолж байв. Жишээлбэл, эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох талаар багш нараас зөвлөгөө авахыг хүсэх байдал нэмэгдэж байгааг тэд ярилцлагадаа дурджээ.




Ишлэл 1. Цэцэрлэгийн багш

...Орчин үед эцэг эхчүүд хүүхдийнхээ хэл ярианы хөгжил, боловсролд ихээхэн ач холбогдол өгдөг болсон. Тэд хүүхдүүдтэйгээ цагийг хэрхэн үр дүнтэй өнгөрөөх талаар багш нараас зөвлөгөө авахыг хүсэж, багш нар нь хүүхдийнхээ хөгжлийн өөрчлөлтийг анзаарсан эсэхийг асуудаг. Энэ нь зарим талаараа эцэг эх, хүүхдүүдийн дунд зохион байгуулсан олон төрлийн аян, үйл ажиллагаа үр дүнгээ харуулж байгаатай холбоотой гэж бодож байна.

Эцэг эхчүүд ном уншиж өгөхдөө хүүхдээсээ бодлого сэтгэхүй хөгжүүлэх асуулт асуух нь маш бага байна. Харин зорилтот хороодын эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 64.3%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 61.4% нь ном уншиж өгөх явцад гаргах хүүхдийн сэтгэл хөдлөлийг ‘байнга’, ‘ихэвчлэн’ хүлээн зөвшөөрдөг гэж хариулсан. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 8.8% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 13.6% нь хүүхдийнхээ сэтгэл хөдлөлийг ‘хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй’ гэж хариулжээ.

Зураг 18. Хүүхдэдээ ном уншиж өгөхдөө сэтгэл хөдлөлөө илэрхийллийг дэмждэг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор



Хүүхдийн унших зуршлыг бий болгоход замын тэмдэг, бүтээгдэхүүний шошгыг хүүхэдтэйгээ хамтдаа уншиж, түүний мэдэхгүй үгийн утгыг тайлбарлах нь үр дүнтэй аргуудын нэг юм. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд хүүхэдтэйгээ уншихтай холбоотой тоглоом тоглохоос илүүтэй замын тэмдэг, бүтээгдэхүүний шошгыг хамтдаа унших, мэдэхгүй үгийн утгыг тайлбарлах үйлдлийг түгээмэл хийж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 60.5% нь хүүхэдтэйгээ хамт замын самбар, бүтээгдэхүүнийг шошгыг уншдаг гэсэн бол 74% нь хүүхдийн мэдэхгүй Монгол болон гадаад үгийн утгыг тайлбарлаж өгдөг гэжээ. Дараах зурагт харуулсанчлан эцэг эх, асран хамгаалагчдын боловсролын түвшин өндөр байх тусмаа тэдний дээрх үйлдлийг хийх түвшин илүү өндөр байна

Зураг 19. Хүүхдэд унших чадвар, зуршил суулгах бусад үйл ажиллагааг хийж буй эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор



Дээр дурдсан үйлдлийг хийж буй эцэг эхчүүдийн хүйсийн хувьд авч үзвэл, аавууд хүүхэдтэйгээ хамт гудамжны самбар унших, мэдэхгүй үгийн утгыг тайлбарлах нь ээжүүдтэй харьцуулахад бага байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэй оролцогчдын 41.7% нь 'байнга', 46.6% нь дээрх үйлдлийг 'ихэвчлэн' хийдэг гэсэн бол эмэгтэйчүүдийн хувь эдгээр хувь тус бүр 58.2%, 53.4% байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан ээжүүд хүүхдэдээ ном уншиж өгөхдөө бодлого сэтгэхүй хөгжүүлэх асуулт асуух, хүүхэдтэйгээ харилцан яриа өрнүүлэх нь илүү өндөр байна.

Зураг 20. Хүүхдийг номонд дуртай болгох бусад үйл ажиллагааг хийж буй эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор




3.3. Эцэг эхчүүд болон хүүхдүүдийн номонд дуртай байдал


Гэр бүлийн болон сургуулийн орчин нь хүүхдийг эцэг эхтэйгээ ойр дотно холбоо үүсгэхэд чухал нөлөөтэйг олон судалгаанд онцолсон байдаг¹⁰. Ялангуяа эцэг эхчүүдийн өөрсдийнх нь унших зуршил нь хүүхэд нь номонд дуртай болоход ихээхэн нөлөөтэй гэж үздэг.

Энэхүү суурь судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчид ном унших дуртай байдал маш доогуур байна. Зорилтот хороодоос судалгаанд хамрагдсан оролцогчдын ердөө 14.8% нь ном унших дуртай байдлаа 'маш өндөр', гэсэн бол 25.3% нь 'өндөр', 28.05% нь 'дунд' гэж үнэлсэн. Үүний адилаар зорилтот бус хороодоос судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 14.8% нь өөрсдийн ном унших дуртай байдлаа 'маш өндөр', 30.3% нь 'өндөр', 33.5% нь 'дунд зэрэг' гэж үнэлсэн. Үүнд боловсролын түвшин болон ном сонирхож байгаа байдал хоёрын хооронд харилцан хамаарал байна.

Зураг 21. Эцэг эхчүүдийн ном унших сонирхол, зорилтот, зорилтот бус хороогоор



Зураг 22. Хүүхдийн ном унших сонирхол, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 23-т харуулсанчлан эцэг эхчүүд хүүхдийнхээ номонд дуртай байдлыг маш дээгүүр үнэлсэн. Өөрөөр хэлбэл, зорилтот хороодын эцэг эхчүүдийн 55.8% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 51.2% нь хүүхдээ номонд 'маш их дуртай', 'дуртай' гэсэн үнэлсэн. Харин зорилтот хороодын эцэг эхчүүдийн 14.8% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 20.8% нь хүүхдээ номонд 'бараг дургүй' гэсэн байна.

10

Durišić, M & Bunjevac, M. 2017 Parental Involvement as an Important Factor for Successful Education. SEPS Journal vol. 7, no 3.


Зураг 23. Хүүхдийн номонд дуртай шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор



Хүүхдүүдийн номонд дурлах болсон шалтгааныг тодруулахад зорилтот хороодоос судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 63.2% нь багш нар хүүхдэд хамгийн нөлөөлдөг гэсэн бол 45.2% нь эцэг эхчүүдийн өөрсдийнх нь ном унших зуршил их нөлөөлдөг гэжээ. Дээрх зургаас харахад үе тэнгийнхэн нь хүүхэд ном сонирхдог болоход үзүүлэх нөлөө харьцангуй бага байна.


Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 75.7% нь хүүхэд зурагт номонд илүү их сонирхолтой байдаг гэсэн бол 45.5% нь номын өнгөнд, 39.5% нь номын хэлбэр дүрсэнд илүү татагддаг гэж хариулжээ. Зорилтот хороодын хүүхдүүдийн ихэнх нь буюу 64% номын зурагт нь илүү татагддаг гэсэн бол 53.2% нь өнгөнд нь татагддаг, харин 50.4% нь хэлбэр дүрсийг нь илүү их сонирхдог гэж хариулсан байна. Үүнээс харвал бага насны хүүхдүүд номын зураг, өнгө, хэлбэр дүрсийг нь илүү их сонирхдог байна.

Зураг 24. Ном уншиж өгөх үед хүүхдийн сонирхдог зүйл, зорилтот, зорилтот бус хороогоор




Эцэг эхчүүдийн ажигласнаар зорилтот хороодын хүүхдүүдийн 35.2% нь ном уншиж буй мэт жүжиглэж, өөрөө өөрсдөдөө үлгэр ярьж өгдөг байна. Үүнийг давтамжаар нь харвал тэдний 20.3% нь 'ихэнхдээ' ийм үйлдэл гаргадаг бол 24.7% нь 'байнга' дээрх үйлдлийг гаргадаг байна. Мөн зорилтот хороодын хүүхдүүдийн 24.7% нь гадуур явах үедээ 'заримдаа' гудамжны самбарын тэмдэг, бичгийг унших сонирхолтой байдал бол хүүхдүүдийн 19.2% нь 'ихэвчлэн', 30.8% нь 'байнга' ийм үйлдэл гаргадаг байна.

Зураг 25. Хүүхэд ном уншиж буй дүр эсгэдэг эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 26. Хүүхэд нь гадуур явахдаа самбарын тэмдэглэгээ сонирхдог эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор



Зорилтот хороодоос судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 1/5 нь буюу 20.9%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 30% нь хүүхдэд ном уншиж өгөхөд 'дуустал нь анхааралтай сонсдог' гэжээ. Харин 'номын багахан хэсгийг анхааралтай сонсдог' гэж зорилтот хороодын эцэг эхчүүдийн 38.1%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 31.3% нь хариулсан байна.

Зураг 27. Ном уншиж өгөх үед хүүхэд нь бүрэн анхаардаг эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор



Судалгааны үр дүнгээс харахад цөөн номтой байх тусам хүүхдэд ном уншиж өгөхөд бага цаг зарцуулдаг төдийгүй хүүхдийн номонд дуртай байдал ч бага байна гэж судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд үзэж байна. Жишээлбэл, судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 44.4% хүүхдэдээ ном уншиж өгөхөд бага цаг зарцуулдаг учраас тэдний хүүхдүүд ном сонирхох нь бага байна гэж хариулсан бол 7.4% нь гэртээ хүүхдэд зориулсан хангалттай ном байхгүйгээс хүүхэд нь номонд дуртай биш байна гэж хариулжээ. Харин зорилтот хороодын эцэг эхчүүдийн 37%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 59.6% нь хүүхдийн ном сонирхох байдал яагаад бага байгаа шалтгааныг сайн мэдэхгүй байна гэж хариулжээ.

Зураг 28. Хүүхдийн номонд дургүй шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор




3.4. Ном унших зуршлыг бий болгоход тулгарч буй бэрхшээлүүд

Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач тус, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа ч хүүхдэдээ ном уншиж өгөх зуршил, тэднийг номонд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагаа бага хэвээр байна. Үүнд гэр болон цэцэрлэгт хүүхдэд зориулсан номын хүртээмж бага байх, хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт бага байгаа нь голчлон нөлөөлж байна.


Зорилтот хороодын эцэг эхчүүдийн 58.1% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 16.9% нь хүүхдэдээ ном уншиж өгөх нь түгээмэл биш байгаагаа өрхийн өөр нэг гишүүн хүүхдэд ном уншиж өгөх үүрэг хариуцлагыг үүрдэгтэй холбоотой гэж тайлбарласан байна. Мөн судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 52.4% нь завгүй учраас хүүхдэдээ ном уншиж өгч чаддаггүй гэсэн ба эдгээрийн дийлэнх нь буюу 74.5% нь сарын дундаж орлого 2 сая төгрөгөөс дээш буюу судалгаанд хамрагдсан өрхүүд дундаа өндөр орлоготой бүлгийн хүмүүс байна.

Зураг 29. Эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгдөггүй шалтгаан, зорилтот, зорилтот бус хороогоор



Хүүхдэдээ ном уншиж өгөх зав гардаггүй гэж хариулсан зорилтот хороодын эцэг эхчүүдийн 20% нь сарын 300,000-500,000 төгрөгийн орлоготой бол, 500,000-700,000 төгрөг (13%), 900,000-1.3 сая (25%), 1.3 саяас дээш орлоготой (37%) байна. Харин зорилтот бус хороодын 1.3 сая төгрөгөөс дээш орлоготой эцэг эхчүүдийн 44% нь завгүй байдаг учраас хүүхдэдээ ном уншиж өгч чаддаггүй гэж хариулсан байна. Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүд өрхийн орлогоо нэмэх бизнес илүү их хийх тусам хүүхдэдээ ном уншиж өгөх цаг хомс болж байгаа нь илэрхий байна.

Зураг 30. Завгүй учраас ном уншиж өгдөггүй эцэг эхчүүд, өрхийн орлого, төгрөгөөр



Хүүхдийн насны онцлогт тохирсон хангалттай олон ном гэрт байхгүй гэж хариулсан эцэг эхчүүдийн талаас илүү нь буюу 57.1% нь гэртээ 3-аас дээшгүй номтой гэж хариулжээ. Чанарын судалгааны мэдээллээс харахад эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь мөн л түгээмэл биш байна. Цэцэрлэгийн багш нар хүүхдийн ном сонирхох байдлыг ихэсгэхэд өрхийн бусад гишүүнээс илүүтэй эцэг эхийн оролцоог нэмэгдүүлбэл илүү үр дүнтэй хэмээн

онцолж байв. Цэцэрлэгийн багш нар аав, ээж нь цэцэрлэгээс нь ирж авдаг хүүхдүүд илүү идэвхтэй, сэтгэл өөдрөг, цэцэрлэгт явахдаа дур, сонирхолтой байгааг ажигласан байна.




Ишлэл 2. Цэцэрлэгийн багштай хийсэн ярилцлагаас

...Эцэг эхчүүд хүүхдээ өсгөхдөө өвөө эмээтэй нь хариуцлагаа хувааж, тэдэнтэй цагийг хамт өнгөрүүлэхээр үлдээдэг. Эцэг эхчүүд үүнийгээ цаг бага байдагтай холбогдуулж тайлбарладаг. Хүүхдийн хөгжлийг дэмжих ямар ч үйл ажиллагааг эцэг эхтэй хамт хийвэл илүү үр дүнтэй байгаа нь харагддаг. Хүүхдүүд ч өөрсдөө эцэг эхтэйгээ шүлэг зохиох, зураг зурах гэх мэт гэрийн даалгавраа хийхдээ дуртай байдаг. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ чанартай цагийг өнгөрөөхийн ач холбогдлын талаар илүү ойлголттой болж байна. Эцэг эхчүүд 7 хоногт дор хаяж 2-3 удаа хүүхдээ өөрсдөө ирж авах хэрэгтэй.

Өрхүүдийн хүүхдэдээ ном худалдан авах чадамж, зорилтот хороодын номын сан, номын дэлгүүрийн хүртээмж бага байгаа нь хүүхдээ бага насанд нь номтой танилцуулах, ном уншиж өгөх соёл бий болоход тодорхой хэмжээгээр саад болж байна. Жишээлбэл, тайлангийн 5 дугаар хэсэгт дурдсанчлан өрхийн ердөө 20.6% нь гэртээ хангалттай олон тооны номтой байна. Тэдгээрийн 48.5% нь гэртээ 3-аас олон хүүхдэд зориулсан номтой гэж хэлжээ. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 51.8% нь гэрийнх нь ойролцоо ямар ч номын сан байхгүй гэж хариулсан. Харин 21.5% нь гэрт ойр номын дэлгүүр байдаг гэжээ. Эцэг эхчүүдийн ердөө 10% нь хамгийн ойр номын сан ороход ойролцоогоор 15-30 минут зарцуулсан гэж хариулжээ.

Бүлгийн дүгнэлт

- Эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхдээ 0-3 насанд нь номтой танилцуулахаас илүү 4-5 насанд нь номтой танилцуулахыг илүүд үзэж байна.
- Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь тэдний боловсролын түвшинтэй хамааралтай байна. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин бага байх тусам хүүхдэдээ ном уншиж өгөх зуршил бага байна. Мөн өрхийн орлогын түвшин өндөр байх тусам эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхөд зарцуулж буй хугацаа бага байна.
- Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгч байхдаа тэдэнтэй харилцах нь харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл, эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгч байхдаа хүүхдээсээ сэтгэхүйг нь хөгжүүлэх, эргэцүүлэн бодох асуулт асуухгүй байна. Харин ном уншиж өгөхөд хүүхдийн гаргаж буй сэтгэл хөдлөлийг шүүмжлэлгүй хүлээн авч байна.
- Эцэг эхчүүд завгүй гэх шалтгаанаар хүүхдэдээ ном уншиж өгөхгүй байгаа нь нийтлэг ажээ. Үүнээс гадна өрхүүд ном худалдаж авах хангалттай мөнгөгүй, хороодод номын хүртээмж, нийтийн номын сан, номын дэлгүүр хомс байгаа нь хүүхдүүд бага насандаа номтой танилцах, номонд дуртай болох нөхцөл хязгаарлагдмал байх нөхцөл болж байна.



**4. ЭЦЭГ ЭХ, АСРАН
ХАМГААЛАГЧИД,
ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ,
МЕНЕЖЕРҮҮДИЙН
ХҮҮХДЭД НОМ
УНШИЖ ӨГӨХИЙН АЧ
ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ
МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ**


Тайлангийн энэ хэсэгт эцэг эх, асран хамгаалагчид, боловсролын байгууллагуудын менежер, багш нар хүүхдийг бага наснаас нь номтой танилцуулах, номтой нөхөрлүүлэхийн ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголтыг хураангуйлан бичив.

4.1. Хүүхдэд ном уншиж өгөх, тэднийг номонд дуртай болгохын ач холбогдол

Хүүхдийг бага наснаас номтой танилцуулж, тэдэнд ном уншиж өгч, номонд дуртай болгох нь хүүхдийн цаашдын амьдралд нь ялангуяа хүүхдийн хэл ярианы хөгжил, бичиг үсэг тайлагдалтад чухал нөлөө үзүүлдэг байна¹¹. Тиймээс эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ном уншиж, түүний зураг, агуулгын талаар харилцан яриа өрнүүлэх нь хүүхдийнхээ хөгжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг ойлгох нь чухал¹².

Эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 41.9% нь хүүхдээ номтой танилцуулах, ном уншиж өгч эхлэхэд хамгийн тохиромжтой насыг 3-5 нас гэж үзсэн бол 39% нь 3 наснаас өмнө дээрх үйл ажиллагаануудыг хийж эхлэх хэрэгтэй гэж үзсэн. Харин эцэг эхчүүдийн 11.3% нь эхийн хэвлийд байхаас үеэс нь хүүхдээ номтой танилцуулах нь тохиромжтой гэж үзжээ. Хүүхэд 7 настай болоход номтой танилцуулж, хүүхдэдээ номонд дуртай болгож эхлэхэд хэтэрхий оройтно гэж эцэг эхчүүд үзжээ.

Зураг 31. Эцэг эхчүүдийн хүүхдийг номтой танилцуулахад тохиромжтой гэж үзэж буй нас




Зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх буюу 40.4% нь хүүхдийг 3-5 насанд нь номтой танилцуулах нь тохиромжтой гэж үзсэн бол зорилтот хорооны хувьд энэ үзүүлэлт 47.3% байна. 0-2 насанд танилцуулах нь тохиромжтой гэж зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 39% нь үзсэн бол энэ насыг сонгосон зорилтот хорооны эцэг эхчүүд 33%-ыг эзэлж байна.


11 Ladd, M. Chang Sandra, M. Levesque, K. (2008). Parents' reading-related knowledge Journal of Educational Psychology, Vol 102(1), Feb 2010, 32-42. doi: 10.1037/a0017288

12 Merga, M. K., & Mat Roni, S. (2018). Empowering parents to encourage children to read beyond the early years. The Reading Teacher, 72(2), 213-221.

Зураг 32. Эцэг эхчүүдийн хүүхдийг номтой танилцуулахад тохиромжтой гэж үзэж буй нас




Зураг 33. Хүүхдээ унших сонирхолтой болгох нь маш чухал гэж үздэг эцэг эхчүүдийн хувь, зорилтот, зорилтот бус хороогоор



Дээрх зурагт үзүүлсэнчлэн зорилтот болон зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхдээ ном унших сонирхлыг хөгжүүлэх нь чухал гэж үзэж байна. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн ихэнх нь (96.2%) болон зорилтот бус хороодын эцэг эхчүүд (96.8%) хүүхдээ ном сонирхдог болгох нь чухал гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна.

Зураг 34. Эцэг эхчүүд хүүхдээ ном унших нь сонирхолтой зүйл гэдгийг ойлгуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүдийн, зорилтот, зорилтот бус хороогоор



Дээрх зурагт үзүүлсэнчлэн ихэнх эцэг эхчүүд хүүхэд ном уншихыг зугаатай зүйл гэж үзэх нь чухал гэдэгтэй санал нийлж байна. Тухайлбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн 95.6% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 97.5% нь хүүхдэд ном унших нь сонгохтой зүйл гэдгийг ойлгуулах хэрэгтэй гэдэгтэй “маш их” болон “зарим талаараа” санал нийлнэ гэж хариулсан байна.

Зураг 34-т харуулсанчлан зорилтот болон зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн боловсролын түвшин өндөр байх тусмаа хүүхдэд ном уншиж өгөх нь тэдний хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг гэдэгтэй санал нэгдэх нь өндөр байна. Дээд боловсролтой эцэг эхчүүдийн 86.5% нь үүнтэй “бүрэн санал нийлсэн”, бол бага болон бүрэн бус боловсролтой эцэг эхчүүдийн 77.2% нь үүнтэй санал нийлжээ.

Зураг 35. Хүүхдээ ном унших сонирхолтой болгох нь чухал гэж үзэж буй эцэг эхчүүд, боловсролоор




Хүүхдээ номонд дуртай болгоход эцэг эхчүүдийн оролцоо чухал гэдгийг судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн менежерүүд онцолж байна. Эцэг эхчүүдийн 97.5% нь хүүхдээ уншиж, бичиж сурахад туслах нь тэдний үүрэг хариуцлага гэж хариулсан байна. Нас, хүйс, өрхийн орлогын түвшингээс үл хамааран эцэг эхчүүдийн дийлэнх нь (96.7%) хүүхдээ багаас нь номонд дуртай болгох нь ‘маш чухал’ гэж хариулжээ. Дээрх үр дүнгээс үзэхэд эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын талаар тодорхой ойлголттой байна.



Ишлэл 3. Цэцэрлэгийн менежертэй хийсэн ярилцлагаас


... Манай цэцэрлэг хүүхдүүдийг номонд дуртай болгох үүднээс олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. Саяхан манай цэцэрлэг “Номтой нөхөрлөө” төсөл хэрэгжүүлсэн. Төслийн хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа нь хүүхдүүдийг номонд дуртай болгохын тулд номтой танилцуулсан. Цэцэрлэг эцэг эхчүүдээс ном цуглуулсан. Эцэг эхчүүд хүүхдүүддээ зориулж ном хийж, урласан. Хүүхдүүд, эцэг эхчүүд цэцэрлэг дээрээ авсан хөтөлбөрийн дагуу хамтран ажилладаг. Төслийн төгсгөлд эцэг эх, багш нар, хүүхдүүд төсөл амжилттай хэрэгжиж дууссаныг тэмдэглэж байсан.

Зураг 36. Эцэг, эхчүүд гэртээ ном сайн уншуулдаг учраас тэд сургууль дээрээ сайн уншдаг гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Дээрх зургаас харахад зорилтот хороодын эцэг эхчүүдийн 86.8% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 85.8% нь 'эцэг эх нь гэртээ хүүхдүүдийг хичээл хийхэд нь сургадаг учраас хүүхдүүд сургууль дээрээ үг уншихдаа сайн байдаг' гэдэгтэй 'бүрэн', 'зарим талаараа' санал нийлж байна. Үүнийг эцэг эхийн насны бүлгээр харвал 20-иос доош насныхан (73.7%) хүүхдэдээ гэртээ үг сурахад нь дэмжлэг үзүүлэх нь хүүхдийн сургуульд амжилттай сурахад чухал нөлөөтэй гэдэгтэй санал нийлж (73.7%) байна.

Зураг 37. Эцэг, эхчүүд гэртээ ном сайн уншуулдаг учраас тэд сургууль дээрээ сайн уншдаг гэж үздэг эцэг эхчүүд, эцэг эхийн насаар




Зураг 38. Эцэг эхчүүд хүүхдэдээ унших, бичих чадварыг эзэмшүүлэх үүрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Зорилтот хорооны 79.1% нь, зорилтот бус хорооны эцэг эхчүүдийн 80% нь 'хүүхдэдээ уншиж, бичих чадвар эзэмшүүлэх нь эцэг эхийн үүрэг' гэдэгтэй 'бүрэн' санал нийлж байна. Харин 'зарим талаараа' санал нийлж буй эцэг эхийн хувь зорилтот хороодод 17%, зорилтот бус хороодод 17.8% байна. Эцэг эхийн боловсролын түвшин өндөр байх тусам хүүхдэд унших, бичих чадвар эзэмшүүлэх үүрэг хариуцлагаа өндрөөр мэдэрч байна. Гэвч тэд хүүхдэдээ ном уншиж өгөх цаг бага гаргадаг гэжээ.

Зураг 39. Эцэг эхчүүд хүүхдэдээ унших, бичих чадварыг эзэмшүүлэх үүрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор




Зураг 40. Үеэр тасалж унших хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд эцэг эх туслах ёстой гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Дээрх зургаас харахад зорилтот хорооны 95.6%, зорилтот бус хорооны эцэг эхчүүдийн 96.4% нь 'хүүхдийн үелж унших чадварыг хөгжүүлэхэд эцэг эх туслах үүрэгтэй' гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна. Үүнийг эцэг эхийн нас, хүйс, боловсролын түвшингээр харахад статистик ач холбогдолтой ялгаа харагдахгүй байна.

Зураг 41. Өөрийн санаа бодлыг цаасан дээр зургаар илэрхийлэх хүсэл, сонирхолтой байх, өөртөө итгэлтэй болоход туслах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор



Зорилтот хороодын 80.8% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 80.5% нь 'хүүхэд үзэл бодол, санаагаа цаасан дээр буулгах сонирхлыг хөгжүүлэхэд эцэг эхчүүд туслах хэрэгтэй' гэдэгтэй 'бүрэн' санал нийлж байна. Харин 'зарим талаараа' санал нийлж буй эцэг эхчүүдийн хувь зорилтот хороодод 15.4%, зорилтот бус хороодод 17.7% байна. Үүнд хүйс, нас, боловсролын түвшингээс хамаарсан статистик ач холбогдолтой ялгаа харагдахгүй байна.

Зураг 42. Сургууль дээр заасан тоолох, уншиж бичих дасгал, даалгаврыг эцэг, эхчүүд гэрт нь давуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор



Эндээс, эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сургуульд сурсан бичиг үсгийг гэрт нь давтан зааж сургах үүрэгтэй гэдгээ ойлгож буй нь харагдаж байна. Зорилтот хороодын 95.1% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 96.2% нь дээрхтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна. Харин зорилтот хороодын 1.1%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 0.2% нь үүнтэй 'огт санал нийлэхгүй' гэж хариулжээ. Үүнд боловсролын түвшингээс хамаарсан ялгаа үгүй байна.

Зураг 43. Сургууль дээр заасан тоолох, уншиж бичих дасгал, даалгаврыг эцэг, эхчүүд гэрт нь давуулах хэрэгтэй гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор




4.2. Бага насанд нь хүүхдэд ном уншиж өгөх ба хүүхдийн хөгжилд үзүүлэх нөлөө, ач холбогдол


Дээр дурдсанчлан эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд олон эерэг нөлөө үзүүлдэг байна. Судалгааны явцад ном уншиж өгөх нь хүүхдийн хэл яриа, танин мэдэхүйн болон нийгэмшихүйн хөгжил, сурлагын амжилтад нөлөөлөхийн зэрэгцээ гэр бүлийн гишүүд хүүхдийн хоорондын харилцаа холбоог илүү бэхжүүлэхэд хэр зэрэг санал нийлж байгааг эцэг эхчүүдээс асуусан.

Доорх зурагт үзүүлсэнчлэн эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхдэд ном уншиж өгөх нь танин мэдэхүйн хөгжилд эерэг нөлөөтэй гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна. Өөрөөр хэлбэл, зорилтот хороодын 95.1% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 93.8% нь хүүхдэдээ ном уншиж өгөх нь тэдний танин мэдэхүйн хөгжилд тустай гэж үзсэн. Үүнд эцэг эхийн хүйсээс хамаарсан статистик ач холбогдолтой ялгаа үгүй байна.

Зураг 44. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 45. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, хүйсээр



Зорилтот хороодын эцэг эхчүүдийн 66.3%, зорилтот бус хороодын 61% нь хүүхдэдээ ном уншиж өгөх нь хүүхдийн нийгэмшихүйн хөгжил буюу сэтгэл хөдлөлөө удирдах, мэдрэмжээ илэрхийлэх, бусадтай харилцах чадварт нь эергээр нөлөөлдөг гэдэгтэй 'бүрэн' санал нийлж байна. 'Зарим талаараа' санал нийлж буй эцэг эхийн хувь зорилтот хороодод 23.5%, зорилтот бус хороодод 30.8% байна.


Үүнээс харвал эцэг эхчүүд хүүхдүүддээ ном уншиж өгөхийн ач холбогдлыг тодорхой хэмжээнд ойлгосон байна. Үүнд эцэг эхийн нас, боловсролын түвшингээс хамаарсан статистикийн хувьд том ялгаа байгаагүй.

Зураг 46. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь нийгэмшихүйн хөгжилд нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Доорх зургаас харахад зорилтот болон зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхдүүдэд ном уншиж өгөх нь хүүхдийн сурлагын амжилтад ихээхэн ашиг тустай хэмээн үзжээ. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн 93%, зорилтот бус хороодын 96.1% нь эцэг эх нь хүүхдэдээ ном уншиж өгөх цагийг чанартай өнгөрүүлсэн тохиолдолд хүүхдүүд сургуульд амжилттай сурах магадлал өндөр байдаг гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна. Үүнд эцэг эхийн боловсролын түвшингээс хамаарсан статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа байгаагүй. Гэсэн хэдий ч дээд боловсролтой эцэг эхчүүдийн 74%, бага боловсролтой эцэг эхчүүдийн 58.6% нь үүнтэй 'бүрэн' санал нийлсэн.

Зураг 47. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь сургуульд амжилттай сурахад нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 48. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь сургуульд амжилттай сурахад нөлөөлнө гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор




Доорх зургаас харахад хүүхдэд ном уншиж өгөх нь эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлэхэд тустай гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж буй хувь ном уншихын бусад ач тус буюу танин мэдэхүйн хөгжил, сурлагын амжилтад үзүүлэх нөлөө зэрэгт өгсөн хувиас арай бага байна. Тухайлбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн 90.2%, зорилтот бус хороодын нийт эцэг эхчүүдийн 89.5% нь 'хүүхдүүд эцэг эхтэйгээ ном уншиж чанартай цагийг хамт өнгөрүүлэх нь холбоо харилцаагаа бэхжүүлэхэд эерэг нөлөөтэй' гэдэгтэй "бүрэн" болон "зарим талаараа" санал нийлж байна. Хүйсээр нь харвал дээрх ач тусыг ээжүүд аавуудаас илүү өндрөөр үнэлж байна.

Зураг 49. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойр дотно болно гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 50. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойр дотно болно гэж үздэг эцэг эхчүүд, хүйсээр




Доорх зургаас харахад зорилтот болон зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхдэд ном уншиж өгөх нь хүүхдийн хэл ярианы хөгжилд тустай гэж үзсэн байна. Зорилтот хороодын эцэг эхчүүдийн 96.5%, зорилтот бус хороодын 97.7% нь хүүхдэд ном уншиж өгөх нь хүүхдийнхээ хэл ярианы хөгжилд тустай гэдэгтэй 'бүрэн' болон 'зарим талаараа' санал нийлж байна. Эцэг эхийн боловсролын түвшин өндөр байх тусам ном унших нь хэл ярианы хөгжилд үзүүлэх нөлөөг илүү өндрөөр үнэлж байна. Тодруулбал, дээд боловсролтой эцэг эхчүүдийн 86.9% нь, бага, дунд боловсролтой эцэг эхчүүдийн 68.4% нь дээрхтэй 'бүрэн' санал нийлж байна.

Зураг 51. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь хэл ярианы хөгжил нь сайжирна гэж үздэг эцэг эхчүүд, зорилтот, зорилтот бус хороогоор



Зураг 52. Хүүхдэдээ ном уншиж өгөх нь хэл ярианы хөгжил нь сайжирна гэж үздэг эцэг эхчүүд, боловсролоор



Мөн цэцэрлэгийн багш, менежерүүд хүүхдэд ном уншиж өгөхийн ач тусыг ойлгож, эцэг эхчүүдийг хүүхдэдээ ном уншиж өгөхийг уриалах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.




Ишлэл 4. Цэцэрлэгийн багштай хийсэн ярилцлагаас

... Хүүхдэд бага наснаас нь ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд олон эерэг нөлөө үзүүлдэг. Энэ нь хүүхдийн хэл ярианы хөгжил, ой тогтоолтод эергээр нөлөөлнө. Мөн хүүхдүүдийн харилцаа, бусдад өөрийгөө илэрхийлэх чадварт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд дараа нь сургуульд элсэхэд болон сурлагын амжилтад нь эерэг нөлөөтэй. Хүүхдэд ном уншиж өгөх нь тэдний танин мэдэхүйн хөгжилд ач тустай. Тиймээс хүүхдүүдээр багшдаа мөн гэр бүлийн гишүүд, найз нөхдөдөө уншсан зүйлээ ярьж өгөх дадлага хийлгэдэг. Хүүхдүүд өөрсдөө их сонирхолтой, дуртай байдаг.


4.3. Нэг болон хоёрдугаар ангийн хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт

Доорх зургаас харахад 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн маш бага хувь нь хүүхдээ сургуульд оруулахаасаа өмнө ном уншиж өгдөг байсан гэж хариулжээ. Тодруулбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 10.9% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 8.8% нь хүүхдэдээ ‘байнга’ ном уншиж өгдөг байсан гэж хариулжээ. Мөн зорилтот хороодын эцэг эхчүүдийн 47.3% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 37.2% нь хүүхдэдээ ‘заримдаа’ ном уншиж өгдөг байсан гэж хариулсан байна. Харин зорилтот хороодын эцэг эхчүүдийн 7.3% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 5.4% нь хүүхдэдээ “огт ном уншиж өгдөггүй” байсан гэж хариулжээ. Хүйсийн хувьд авч үзвэл, ээжүүд (11.6%) аавуудыг (0%) бодвол хүүхдэдээ ном уншиж өгөх нь илүү байсан.

Зураг 53. Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан эсэх, зорилтот, зорилтот бус хороогоор




Зураг 54. Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан эсэх, хүйсээр



Нэг болон хоёрдугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдэдээ ном унших өгөх нь бага байсан хэдий ч ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд үзүүлэх эерэг нөлөөтэйг ойлгож байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 64% нь ном унших нь хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэхэд ‘маш чухал’ гэж үзсэн бол хэл ярианы хөгжил (59%), анхаарлаа төвлөрүүлэх чадварт (56%) нь ‘маш чухал’ нөлөөтэй гэж үзсэн. Харин хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд үзүүлэх нөлөөнд эцэг эхчүүд (40%) хамгийн бага ач холбогдол өгч буй нь судалгааны үр дүнгээс харагдсан.

Зураг 55. Нэг болон хоёрдугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ сургуульд явуулахын өмнө ном уншиж өгөхийн чухлыг хэрхэн харж байгаа эсэх



Хүснэгт 4. Эцэг эхийн хүүхдээ бага насанд нь номтой танилцуулах ач холбогдол ба тэдний унших дадал хоорондын хамаарал


Зүйл		Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан давтамж	Хүүхдийг сургуульд орохоос нь өмнө номтой нөхөрлүүлэх нь ач холбогдолтой гэж үзэж буй байдал
Хүүхдэдээ сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгдөг байсан давтамж	Персоны корреляц	1	.778**
	Ач холбогдол (2-сүүлт)		0.000
	Түүврийн тоо	203	203
Хүүхдийг сургуульд орохоос нь өмнө номтой нөхөрлүүлэх нь ач холбогдолтой гэж үзэж буй байдал	Персоны корреляц	.778**	1
	Ач холбогдол (2-сүүлт)	0.000	
	Түүврийн тоо	203	203

** . Корреляцийг 0.01 түвшинд ач холбогдолтой гэж үзнэ. (2-сүүлт).

Дээрх хүснэгтэд харуулсанчлан сургуульд орохоос нь өмнө ном уншиж өгөх нь чухал эсэхийн ач холбогдлыг үнэлсэн байдал нь хоорондоо хүчтэй хамааралтай байна. Өөрөөр хэлбэл 0,776** нь хамаарал хүчтэй байгааг илтгэнэ. ** нь 95 %-ийн статистик ач холбогдолтойг илтгэнэ. Сургуульд элсэхээс өмнө ном уншиж өгөх тусам хүүхдийнх нь хөгжилд чухал нөлөө үзүүлдэг нь эндээс харагдаж байна.

Бүлгийн дүгнэлт

- Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ цагийг сайхан өнгөрүүлж, ном уншиж өгөх нь чухал гэдгийг ойлгож байгаа ч хүүхдээ номтой танилцуулах, номонд дуртай болгох хамгийн тохиромжтой үеийг 4, 5 нас гэж үзэж байна.
- Хүүхдийн ном унших сонирхлыг хөгжүүлэх нь чухал гэдэгтэй ихэнх эцэг эхчүүд санал нийлж байна. Нөгөөтээгүүр, гэртээ бичиг үсэг, тоо сурах нь хүүхдүүддээ сургуульд үг уншиж өгөхөд тустай эсэхэд тийм ч итгэлтэй биш байна. Харин эцэг эхчүүд хүүхдээ сургуульд сурч, тодорхой чадвараа хөгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.
- Эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд олон эерэг нөлөө үзүүлдэг гэдэгтэй санал нийлж байна. Судалгаанд эцэг эхчүүд хүүхдэд ном уншиж өгөх нь тэдний танин мэдэхүйн хөгжил, сурлагын амжилт зэрэгт эерэг нөлөөтэй гэж үзэж байна. Харин хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд үзүүлэх нөлөөнд эцэг эхчүүд хамгийн бага ач холбогдол өгч буй судалгааны үр дүнгээс харагдсан. 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн маш бага хувь нь хүүхдээ сургуульд элсэхээс өмнө ном уншиж өгч байсан гэж хариулжээ. Хүйсийн хувьд энэ үзүүлэлтийг харьцуулж үзэхэд ээжүүд (11.6%) аавуудыг (0%) бодвол хүүхдэдээ ном уншиж өгөх нь илүү байсан.
- 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдэдээ ном унших өгөх нь бага байсан хэдий ч ном уншиж өгөх нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг гэдгийг ойлгож байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх нь танин мэдэхүй, хэл ярианы хөгжилд маш чухал нөлөөтэй. Харин хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд үзүүлэх нөлөөнд хамгийн бага ач холбогдол өгч буй нь судалгааны үр дүнгээс харагдсан.

A photograph of a child sitting on the floor reading a book. The child is wearing striped pants and is surrounded by several potted plants. The scene is bathed in a warm, orange-red light, creating a cozy atmosphere. The text is overlaid on the image in a bold, white, sans-serif font.

**5. ХҮҮХДИЙН НОМЫН
ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ
БОЛОН СУРГУУЛИЙН
ӨМНӨХ НАСНЫ
ХҮҮХДЭД НОМ УНШИЖ
ӨГӨХИЙГ ДЭМЖСЭН
БОДЛОГЫН ОРЧИН**

Тайлангийн энэ бүлэгт гэр болон цэцэрлэгт хүүхдэд зориулсан номын хүртээмжтэй болон бэлэн байдлыг, сургуулийн өмнөх насны хүүхдэд ном уншиж өгөхийг дэмжихтэй холбоотой бодлого, эрх зүйн орчны тухай цуглуулсан мэдээллээ хураангуйлан бичив.


5.1. Гэрт болон цэцэрлэг дээрх хүүхдэд зориулсан номын хүртээмжтэй байдал болон бэлэн байдал

Бага насны хүүхдийн амьдрах, хөгжих боломжийг тодорхойлоход хүрээлэн буй орчин нь чухал үүрэг гүйцэтгэдэг¹³. Аюулгүй, зохион байгуулалт сайтай орчин гэдэгт хүүхдийн тоглох, судлах, нээн илрүүлэх боломж, хөгжилд тохирсон эд зүйл, тоглоом, ном зэрэг зүйлс багтана¹⁴. Номтой айлд өссөн хүүхдүүд номгүй айлынхтай харьцуулахад суралцах хугацаанаас гурван жилээр илүү байдгийг судалгааны үр дүн харуулсан байдаг¹⁵.

Энэ судалгаанд хүүхдэд зориулсан номын хүртээмжтэй байдлыг 11 үзүүлэлтээр шалгаж үзлээ. Судалгааны үр дүнг шинжилж үзвэл хүүхэд гэртээ болон цэцэрлэг дээрээ номтой танилцах боломжтой гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын хариулыг нэгтгэж үзвэл нийт 1 оноо авахаас 0.7 оноо авсан нь уг дүгнэлтийг баталж байгаа юм. Түүнчлэн номын хүртээмжтэй байдлыг зорилтот ба зорилтот бус хороогоор харьцуулж үзвэл бараг ялгаагүй (зорилтот хороодын түвшинд 0.71, зорилтот бус хороодод 0.70) гарлаа.

Номын хүртээмжтэй байдлыг үзүүлэлт бүрээр тодруулж үзвэл гэртээ 20-оос дээш номтой өрх зорилтот хороодод 35.7%, зорилтот бус хороодод 47.9% байна. Харин 1-5 номтой айл зорилтот хороонд 14.8%, зорилтот бус хороодод 24.7% байна.

Зураг 56. Судалгаанд оролцсон өрхүүдийн номын санд буй номын тоо, зорилтот болон зорилтот бус хороогоор, зорилтот, зорилтот бус хороогоор



Эдгээрээс зорилтот хороодоос судалгаанд оролцогчид гэртээ дунджаар 9 номтой, зорилтот бус хороонд 12 номтой байна. Үүнийг орлогын түвшингээр харьцуулбал статистик ач холбогдолтой ялгаа харагдахгүй байна. Харин хүүхдийн асран хамгаалагчдын боловсролын түвшинг харьцуулахад мэдэгдэхүйц ялгаатай байна. Эцэг эх нь дээд боловсролтой хүүхдийн гэрт дунджаар 13 ном байгаа бол бага, суурь боловсролтой асран хамгаалагчдын гэрт дунджаар 7 ном байна. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин өндөр байх тусам гэртээ олон номтой, түүнээс хүүхдэд зориулсан номын эзлэхувь өндөр байна.

13 Belsky, Jay, et al., 'Socioeconomic Risk, Parenting During the Preschool Years and Child Health Age 6 Years', *European Journal of Public Health*, vol. 17, no. 5, 14 December 2006, pp. 511–512.

14 Dobrova-Krol, Natasha A., et al., 'Effects of Perinatal HIV Infection and Early Institutional Rearing on Physical and Cognitive Development of Children in Ukraine', *Child Development*, vol. 81, no. 1, January/February 2010, pp. 237–251.

15 Evans, Maria D.R., et al., 'Family Scholarly Culture and Educational Success: Books and schooling in 27 nations', *Research in Social Stratification and Mobility*, vol. 28, no. 2, June 2010, pp. 171–197.

Зураг 57. Судалгаанд оролцогчдын гэрт буй хүүхдэд зориулсан номын тоо, зорилтот, зорилтот бус хороогоор




Судалгаанд оролцогчдын ном худалдаж авахад зарцуулдаг мөнгөний хэмжээг судлахад зорилтот хороодод (12.6%), зорилтот бус хороодод (10.4%) иргэд ном худалдаж авахад мөнгө огт зарцуулдаггүй байна. Дийлэнх өрхүүд (2/3) ном худалдаж авахад хааяа мөнгө зарцуулдаг ба нийт оролцогчдын 1/5 хувь нь тогтмол мөнгө зарцуулдаг байна. Үүнээс хүүхдийн номонд мөнгө зарцуулдаг хувь зорилтот хороодод (25.8%), зорилтот бус хороодод (28.6%) байна.

Боловсрол, соёлын үйл ажиллагаанд зарцуулах зардал нь тухайн өрхийн орлого, боловсролын түвшинтэй шууд хамааралтай байна. Манай судалгааны хувьд ч мөн адил судалгаанд оролцогчдын орлогын түвшин их байх тусам өрхөд буй номын тоо, түүнээс хүүхдэд зориулсан номын тоо бусад орлогын түвшний бүлэгтэй харьцуулахад өндөр байна.


Судалгааны үр дүнгээс харвал судалгаанд оролцогчид хүүхдэдээ зориулж ном худалдаж авч өгөхдөө ном нь хүүхдийн насны онцлогт тохирсон байхыг (зорилтот хороодод (81.9%), зорилтот бус хороодод (74.1%)) хамгийн их илүүд үзэж байна. Түүнчлэн хүүхдийн сонирхолд нийцсэн байх, бичвэр багатай, зураг ихтэй байхыг илүүд үзэж байгаа бол үнэ боломжийн байхыг (зорилтот хороодод 22.5%, зорилтот бус хороодод 20.3%) илүүд үзсэн.

Зураг 58. Судалгаанд оролцогчдын хүүхдэдээ зориулж ном худалдаж авахдаа ач холбогдол өгдөг зүйлс, эрэмбээр



Энэ үзүүлэлт нь судалгаанд оролцогчдын орлого болон боловсролын түвшингээс хамаарсан ялгаатай байна. Харин эцэг эхчүүдийн хамгийн их ач холбогдол өгч буй хүүхдийн насны онцлогт тохирсон ном худалдан авахад тулгардаг түгээмэл бэрхшээлд “амьдардаг газарт ойр номын дэлгүүр байдаггүй” гэсэн хариулт хамгийн их буюу зорилтот хороодод 74.7%, зорилтот бус хороодод 45.4% байна. Түүнчлэн “ном хэтэрхий үнэтэй”, “монгол хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон номын олдоц хязгаарлагдмал” гэсэн бэрхшээлүүд нийтлэг дурдагджээ. Харин судалгаанд оролцогчид санхүүгийн бэрхшээл тулгардаг гэсэн хариултыг зорилтот хороодод 22.5%, зорилтот бус хороодод 14.5% нь өгсөн байна.

Зураг 59. Судалгаанд оролцогчид хүүхдэдээ ном худалдан авахад тулгардаг нийтлэг бэрхшээлүүд, зорилтот ба зорилтот бус хороогоор



Дээрх нөхцөлийг ялангуяа зах зээлд борлуулагдаж буй номуудын хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн байдал дутмаг, сонголт хязгаарлагдмал байгааг гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцсон сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын бодлого боловсруулагчид дурдаж байв.




Ишлэл 5. БШУЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

... Бодлогын түвшинд хүүхдийн номын нарийвчилсан стандарт, шалгуурыг боловсруулах шаардлага байна. Номын агуулга, материал, хавтас, зохиол зэрэг бүх зүйл дээр тавигдах шалгууртай байвал зүгээр. Ийм шалгуур байдаггүйн улмаас дураараа, хаа хамаагүй номыг орчуулан хэвлэх тохиолдол их байдаг. Эцэг эхчүүд хүүхдэдээ ном сонгохдоо номын үзэмж, эсвэл, хүүхдийнхээ хүслээр сонгодог. Дотоод агуулга, мөн чанарыг хянах боломж тийм ч их байдаггүй

Судалгааны үр дүнгээс харахад гэр болон цэцэрлэг дээрээ номыг тодорхой, тогтсон байршлаас насанд хүрсэн хүний тусламжгүйгээр хүүхэд авч танилцах, тоглох боломж хангалттай сайн байна. Хүүхдэд зориулсан номыг тогтсон байршилд тавих нь номтой танилцах, номонд дуртай болоход нөлөөлдөг тухай эцэг эх, асран хамгаалагчид, цэцэрлэгийн арга зүйч, багш нарын ойлголт харьцангуй сайн байгааг илтгэж байна.

Харин хэвлэмэл номыг унших боломжтой байдал зорилтот хороодод 85.7%, зорилтот бус хороодод 90.4% байна. Үлдсэн 10 хүрэхгүй хувь нь цахим ном унших боломжтой байна. Үүний адил судалгаанд оролцогчдын дунд хэвлэмэл номыг илүүд үзэх байдал давамгайлж байна. Тодруулбал, зорилтот хороодод 77.6% хэвлэмэл номыг илүүд үзэж байгаа бол цахим номыг илүүд үзэх байдал 13.7%-тай байна. Энэ нь иргэдийн дунд цахим номын хэрэглээ бага, түүнийг хэрэглэх ойлголт, туршлага бага байгаатай холбоотой байх магадлалтай.

Зураг 60. Уншдаг номын хэлбэр ба илүүд үздэг номын хэлбэр, зорилтот ба зорилтот бус хороогоор



Эцэг эх, асран хамгаалагчид нь хэвлэмэл номыг хүүхдэд ихэвчлэн худалдаж авч өгдөг байдал зорилтот хороодод 90.7%, зорилтот бус хороодод 91.9% байна. Зээлж авч үзүүлдэг тохиолдол бага буюу нийт судалгаанд хамрагдсан хороодын түвшинд 2% хүрэхгүй байна. Харин эсрэгээрээ цахим хэлбэрийн ном худалдан авч өгдөг хувь зорилтот хороодод 18.1%, зорилтот бус хороодод 10.8% байна. Үлдсэн хэсэг нь цахим номыг сонирхдоггүй байна

5.2. Сургуулийн өмнөх насны хүүхдэд ном уншиж өгөхийг дэмжсэн бодлого, эрх зүйн орчин

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхдэд хүргэхэд чиглэсэн хэд хэдэн эрх зүйн болон бодлогын баримт бичиг хэрэгжиж байна.

Хүснэгт 4. СӨБ-ын талаар хэрэгжиж буй гол эрх зүй, бодлогын баримт бичгүүд

Баримт бичгийн нэр	Баталсан байгууллага	Огноо
Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль	УИХ	2008
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого	БСШУ, ЭМ, НХХ-ийн сайдын 116/83/45 дугаар тушаал	2005
Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх журам	БСШУ-сайдын А/293	2013
Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай	БСШУ-сайдын А/145	2019
Сургалтын хөтөлбөр батлах тухай	БСШУ-сайдын А/181	2018

Баримт бичгийн нэр	Баталсан байгууллага	Огноо
Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм	БСШУ-сайдын А/118	2019
Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай /Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш/	БСШУ-сайдын А/118	2019
Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөр	БСШУ-сайдын А/487	2018
Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам	БСШУ-сайдын А/804	2019
Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаанд баримтлах чиглэл	БСШУ-сайдын А/164	2020
Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам	БСШУ-сайдын А/184	2020
Сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай	БСШУ-сайдын А/278	2020
Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам	БСШУ-сайдын А/280	2020

Эдгээр баримт бичигт сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох талаар онцгойлон дурдсан зүйл заалт нарийвчлан тусгаагүй байна. Гэсэн хэдий ч, цэцэрлэгүүд хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зорилгынхоо хүрээнд номтой танилцуулах, номонд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Жишээлбэл, аймаг, дүүрэг, нийслэлийн хэмжээнд тодорхой аян, эсвэл, ном цуглуулах, номтой танилцуулах, цэцэрлэг болон бүлэгтээ номын сантай байх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хүүхдийг сурч боловсроход таатай орчин бүрдүүлэхэд эцэг эх, дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой зүйл заалтууд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд (2008), Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөр (2018)-т байдаг. Эдгээр заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эцэг эхчүүд гэртээ хэрэглэхгүй байгаа номоо авчирч, номын сан бүрдүүлэх, хоорондоо ном солилцож хүүхдэдээ уншиж өгөх зэрэг олон ажлыг санаачлан хийдэг туршлагауд байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам 2020 онд Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам баталсан. Энэ журмын дагуу анх удаа, туршилтын журмаар үндэсний хэмжээнд 24,000 нэгдүгээр ангид элссэн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааг зохион байгуулсан байна.

Уг үнэлгээний журамд унших, бичихэд бэлтгэгдсэн байдлыг илрүүлэх шалгуур тусгагдсан байдаг бөгөөд судалгааны үр дүнг холбогдох бодлого, хөтөлбөрүүдэд тусгасан байна.

Үүнээс гадна Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан болон Үндэсний статистикийн хороотой хамтран хийсэн Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгааны үр дүнг сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого, үйл ажиллагаанд тусгасан байна.

Гэр бүл нь хүүхдийг идэвхтэй дэмжиж байвал тэрээр сургуульд амжилттай суралцах магадлал өндөр байдаг. Цаашлаад, гэр бүлийн гишүүд хүүхэдтэйгээ хамт ном унших, гэрийн даалгавар хийхэд туслах, багш нартай нь ярилцах, сургууль болон бусад сургалтын үйл ажиллагаанд оролцох нь маш олон давуу талтай байдгийг олон жилийн судалгаа нотолжээ.¹⁶

Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, боловсролын байгууллагын хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгож, ашиг тусыг нь цохон тэмдэглэж байна. Хүүхдийн хөгжилд оруулах эцэг эхийн хувь нэмрийг нэмэгдүүлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, гэр бүлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилготой олон төрлийн үйл ажиллагааг цэцэрлэгүүд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулж байна. Ялангуяа цар тахлаас шалтгаалсан хөл хорионы үед эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, боловсролын байгууллагын хамтын ажиллагааг илүү бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулжээ.

Боловсролын салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн чанарын судалгааны ярилцлагын үеэр эцэг эхчүүдэд зориулсан хүүхэдтэйгээ ажиллах арга зүйн сургалт болон бусад үйл ажиллагааг цэцэрлэгүүд зохион байгуулсан тухай дурдаж байлаа.

Түүнчлэн дүүрэг, цэцэрлэгийн хэмжээнд хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход чиглэсэн эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагуудын хамтран зохион байгуулсан уралдаан тэмцээн, бусад үйл ажиллагааны тухай сайн туршлагуудын тухай ч тэд дурссан байдаг.



Ишлэл 6. Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн багштай хийсэн ярилцлагаас

... Дүүргийн боловсролын газраас сурагчдын амралттай холбоотойгоор номтой нөхөрлөө аяныг санаачлан зохион байгуулсан. Энэ аяны хүрээнд багш нар өөрсдийн үр чадварыг хөгжүүлэх сургалтад хамрагдсаны дагуу цахим ном хийсэн. Цэцэрлэгийн зүгээс цахим ном бүтээж, түүнийгээ эцэг эхчүүдэд хуваалцаж хүүхдүүддээ ном уншиж өгөх боломж олгосон нь их онцлог байсан. Энэ нь шинэ ном худалдаж авах санхүүгийн боломжгүй, хүүхдэдээ ном уншиж өгдөг дадалгүй эцэг эхчүүдэд чухал боломж байв.

...Мөн багш нар 2 сард монголын нууц товчоог уншиж тэмцээн зохиосон. 2014 онд манай цэцэрлэгт эцэг эх багш хүүхдүүд бүгд ном хийгээд номын богц аялуулан өдөр бүр номоо солилцож уншдаг байсан. Хүүхдүүдийн уншсан номын жагсаалтыг гаргаад хэн хамгийн олон ном уншиж танилцсаныг дүгнэж, урамшуулдаг байсан. Энэ ажил их үр дүнтэй байсан. Үүний үр дүнд эцэг эхчүүдийн идэвх оролцоо ч үүнийг бас дагаад нэмэгдсэн.

16 Belsky, Jay, et al., 'Socioeconomic Risk, Parenting During the Preschool Years and Child Health Age 6 Years', *European Journal of Public Health*, vol. 17, no. 5, 14 December 2006, pp. 511–512.

66

Ишлэл 7. Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн багштай хийсэн ярилцлагаас

...Зарим эцэг, эхчүүд хүүхэдтэйгээ ном унших арга барилын тухай багш нараас нь шууд асуухаас нэрэлхэж санаа нь зовдог. Тиймээс манай цэцэрлэг “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв” байгуулсан. Энэ төвөөрөө дамжуулаад эцэг эхчүүдэд хүүхдэдээ ном танилцуулах, номонд дуртай болгох талаар мэдээлэл өгдөг. Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв маань цар тахлын үед гар утсаар холбогдох хэлбэрээр ажилласан. Энэ үед эцэг эхчүүд танхимаар зөвлөгөө авдагсаа ч илүү заавар, зөвлөгөө авсан. Нөхцөл байдал хэвийн болсон ч гэсэн бид гар утсаар зөвлөгөө өгөх ажлаа үргэлжлүүлнэ гэсэн бодолтой байгаа. Утсаар холбогдох үед хүүхдийн хүмүүжил, ном уншиж өгөх арга хэлбэрийн талаар зөвлөгөө авахдаа заавал нэр, хаягаа хэлээд байх шаардлагагүй нь эцэг эхэд их таалагддаг.

66

Ишлэл 8. Сүхбаатар дүүргийн цэцэрлэгийн багштай хийсэн ярилцлагаас

... Эцэг эхчүүдийг татан оролцуулах чиглэлээр АХА тэмцээн, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж байсан. Одоогоор цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор иймэрхүү үйл ажиллагааг зохион байгуулахгүй байна. Эцэг эхчүүдийн хувьд хүүхдэдээ ном уншиж өгөх нь ховор байгаа бөгөөд ялангуяа манай хорооныхон энэ тал дээр учир дутагдалтай байгаа санагддаг.

Хүүхдийг номонд дуртай болгох, номтой танилцуулахад багш нарын үүрэг оролцоо их. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) (одоогийн Боловсролын ерөнхий газар) нь Монгол Улсын бүх шатны боловсролын байгууллагын багш, боловсон хүчний чадавхыг сайжруулах төрийн үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Энэ байгууллагаас цэцэрлэгийн багш нарын хэрэгцээнд тулгуурласан сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, тэднийг чадавхжуулдаг. Хамгийн ойрын нэг жишээ бол БМДИ-ээс 2020 онд аймгуудын бүх мэргэжилтнийг оролцуулан “гурав хүртэлх насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих” сургалт, үйл ажиллагаа зохион байгуулжээ. Түүнчлэн олон улсын байгууллагууд цэцэрлэгийн багш нарыг чадавхжуулах ажилд оролцож байна. Жишээлбэл, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн боловсролын газар нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагуудыг чадавхжуулах сургалтыг 2020 онд зохион байгуулсан байна.

Цэцэрлэгүүд бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах зорилгынхоо хүрээнд хүүхдэд ном уншиж өгөх, номтой танилцуулах, номонд дуртай болгоход чиглэсэн зүйл заалтыг багшийн ажлын байрны тодорхойлолтод өөр өөрийн хэмжээнд харилцан адилгүй тусган хэрэгжүүлж, энэ чиглэлээр өөрсдийн багш нарыг чадавхжуулан ажиллаж байна. Багш нараа чадавхжуулах чиглэлээр зохион байгуулж буй сургалтын агуулга, чиглэл нь ч мөн адил цэцэрлэгүүдэд харилцан адилгүй, ялгаатай байна. Ихэнх цэцэрлэгүүд хүүхдэд ном уншиж өгөх, тайлбарлах ажлыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг байна.

66


Ишлэл 9. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хийсэн ярилцлагаас

... Ховдын нэг цэцэрлэгийн эрхлэгч үндэсний соёл, уламжлалаа хүүхдэд өвлүүлэх ач холбогдолтой ажлуудыг санаачлан хийдэг. Тухайлбал, Монгол ардын тоглоом наадгайг сэргээн, хүүхдүүдээр тоглуулж байсан. Мөн амьтдын нэр тогтоох, нэмэх, хасах үйлдэл хийх, гарын жижиг булчинг хөгжүүлэх зэрэг хүүхдийн хөгжилд чухал нөлөөтэй үйл ажиллагааг ч санаачлан хийдэг. Манай сургалтын хөтөлбөрийн агуулга уян хатан чөлөөтэй байдаг учир ийм ажлыг санаачлан хийхэд тохиромжтой төдийгүй цааш нь хөгжүүлэх бүрэн боломжтой байдаг онцлогтой.

5.3. Номын дэлгүүр, номын сан, нийтийн ном унших төвүүдийн хүртээмжтэй байдал


Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт”-д анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлагыг тусгасан байдаг. Энэ стандартыг мөрдөхөд хүүхдийн хөгжлийг цогцоор нь хангах орчин бүрдэнэ гэж үздэг. Хэдий тийм ч эцэг, эхчүүдээс авсан судалгаа болон цэцэрлэгийн арга зүйчидтэй хийсэн ярилцлагаас харахад хүүхдэд гэрт нь болон цэцэрлэг дээр номын хүртээмжтэй байдал хангалтгүй байна. Номын хүртээмжтэй байдлыг гурван үзүүлэлтээр хэмжсэн. Ингэхэд нийт 1 оноо авахаас эцэг, эхчүүд хүүхдүүдэд зориулсан номын хүртээмжтэй байдлыг (зорилтот хороодод 0.48, зорилтот бус хороодод 0.46) “хангалтгүй” гэж үнэлсэн. Үзүүлэлтээр нь нарийвчлан харвал судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн дийлэнх нь (зорилтот хороодод (47.7%), зорилтот бус хороодын (44.7%)) 1 цагаас илүү зайг туулж номын санд очих боломжтой гэж хэлжээ. Харин 15 минут дотор очих боломжтой гэж зорилтот хороодод 3.4%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 12.2% нь хариулсан. 31 минутаас 1 цагийн хооронд явах зайд очих боломжтой гэж зорилтот хороодын 39.1%, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 26.3% нь хариулжээ.

Зураг 61. Гэрээсээ хамгийн ойр номын сан ороход зарцуулж буй хугацаа, минутаар



Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүд насанд хүрэгчдийн тусламжгүйгээр ихэвчлэн гэртээ номтой хамгийн ойр (зорилтот хороо 62.1%, зорилтот бус хороодод 79.7%) байна. Цэцэрлэг болон хүүхэд харах үйлчилгээний төвд (зорилтот хороодод 34.5%, зорилтот бус хороодод 17.4%) хүүхдүүд номтой хамгийн ойр байна. Харин ихэнх баг, хорооны нутаг дэвсгэрт хүүхэд, олон нийтэд зориулсан номын сан байхгүй байна. Гэвч зарим нэг дүүрэг, хороод өөрийн байрны нөөц боломжийг ашиглан 1 өрөөг номын сан болгон тохижуулж, иргэдэд үйлчилдэг сайн туршлагууд байна. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн 43 дугаар хороонд нэг өрөөгөө номын сан болгож тохижуулан, олон нийтийн хандиваар ном цуглуулсан төдийгүй цаашид уншлагын танхимтай болохоор төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн Сүхбаатар дүүргийн 31 дүгээр хорооны Иргэний танхимд ном цуглуулж, фонд үүсгэн олон нийтэд нээлттэй үйлчлэн, ном унших боломжоор хангажээ. Гэвч КОВИД-19 цар тахлын улмаас хүмүүс ирж үйлчлүүлээгүй байна.

Зураг 62.Эцэг эхчүүдийн бодлоор хүүхэд нь номтой хамгийн ойр байдаг газар, зорилтот, зорилтот бус хороогоор



Чанарын судалгаанд хамрагдсан оролцогч талуудын ярилцлагаас харахад цэцэрлэгийн номын сангийн хүртээмж нь түүнд зориулсан төсвийн хүрэлцээтэй байдлаас шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, хувьсах зардлын бага хэсэг нь бичиг хэргийн зардалд төсөвлөгддөг ба энэ нь хүүхдүүдэд зориулсан номыг байнга сэлбэн шинэчлэх нөхцөлийг хязгаарлаж байна. Тиймээс цэцэрлэгийн багш нар өөрсдөө болон бэлтгэл, ахлах бүлгийн хүүхдүүдтэйгээ хамтран ном бүтээх замаар хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох ажлыг санаачлан хийж байна. Багш нар цэцэрлэгийнхээ цахим хуудсанд цахим ном байршуулж, хүүхдэдээ ном уншиж өгөх даалгаврыг эцэг эхчүүдэд өгдөг жишээ ч байна.

Судалгаанд хамрагдсан бодлого боловсруулагчид, судлаачид болон мэргэжлийн хүмүүс зах зээлд байгаа хүүхдэд зориулсан номын чанар, агуулга, хүртээмжтэй байдалд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлжээ. Тэдний дүгнэж байгаагаар монгол хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, монгол зохиолчдын бичсэн, чанартай, сайн агуулгатай хүүхдэд зориулсан ном бүтээх ажлыг бодлогын түвшинд болон олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор хийх зайлшгүй шаардлагатай байгааг цохон тэмдэглэж байлаа. Энэ ажлыг зөв төлөвлөлт, удирдлага зохион байгуулалттай өрнүүлж чадвал монгол уламжлал соёлоо үлгэр, номоор дамжуулан хүүхдэд өвлүүлэх, хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болоход ихээхэн дэмжлэг үзүүлэх юм.

Бүлгийн дүгнэлт

- Сургуулийн өмнөх насны хүүхдүүд гэртээ болон цэцэрлэг дээрээ номтой танилцах, номонд дуртай болох орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна. Эцэг эхийн боловсролын түвшин нэмэгдэх тусам хүүхдэд зориулсан ном авч, уншиж өгөх хандлага өндөр байгаа ч өрхийн орлогын чадавхаас хамаарч ном худалдаж авах нь харьцангуй бага, хязгаарлагдмал байна.
- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байдал нь номыг сонгох гол шалгуур болж байна. Түүнчлэн эцэг эхчүүд бага бичвэртэй, зураг ихтэй байх, үнэ боломжийн байх зэрэгт ач холбогдол өгч байна. Харин боловсролын байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харахад Монгол улсад хүүхдийн номонд тавих нэгдсэн шалгуур, стандартыг шинэчлэн батлах шаардлага байна.
- Эцэг, эхчүүд болон боловсролын байгууллагууд хүүхдэд номыг насанд хүрсэн хүний тусламжгүйгээр хүрч, танилцах боломжийг хангалттай түвшинд бий болгосон ба түүний ач холбогдлын талаарх ойлголт харьцангуй сайн байна.
- Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд эцэг, эхчүүд цахим ном уншиж өгч, хэрэглэж хэвшээгүй хэвээр байна. Харин зарим цэцэрлэгийн зүгээс өөрсдийн цахим хуудсанд цахим ном байршуулж эхэлсэн нь хэвлэмэл ном худалдаж авах боломжгүй өрхүүдийн хувьд хүүхдэдээ ном уншиж өгөх, гэрийн даалгаврыг нь хийлгэхэд туслах ач холбогдолтой байна.
- Сургуулийн өмнөх боловсролын эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд сургуулийн өмнөх насны хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох талаар онцгойлон дурдсан зорилт, зүйл заалтыг нарийвчлан тусгаагүй ч хүүхдийн цогц хөгжлийн хангах зорилтынхоо хүрээнд боловсролын бүх шатны байгууллагууд энэ агуулгыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.
- Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход судалгаанд хамрагдсан оролцогч талууд болох эцэг эх, асран хамгаалагчид, хүүхэд, боловсролын байгууллагын гурвалсан хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгож, ашиг тусыг нь цохон тэмдэглэж байна. Цэцэрлэгүүд эцэг эхчүүдийн хүүхдийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаагаа сайжруулах зорилгоор өөрсдийн нөөц бололцоонд тулгуурласан үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Судалгаанд хамрагдсан хороодод хүүхэд, олон нийтэд зориулсан номын сан, уншлагын танхим, номын дэлгүүр маш хомс байна.

**6. ХҮҮХДИЙН
ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ САЙН
ТУРШЛАГА, НИЙТЛЭГ
СОРИЛТУУД**

Тайлангийн энэ хэсэгт хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг гэр болон цэцэрлэгт зохион байгуулж буй байдал, 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын дунд хүүхдэд ном уншиж өгөх зуршлыг бий болгох, эцэг эхчүүд болон боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, сонгогдсон хороодод боловсролын үйлчилгээнээс хоцрох эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн нөхцөл байдлын талаар хураангуйлан бичив. Энд буй мэдээллийн агуулга нь ихэвчлэн чанарын судалгаанд тулгуурласан бөгөөд цэцэрлэгийн багш, эрхлэгч, арга зүйч, хороодын нийгмийн ажилтан, засаг дарга нар, нийслэл, дүүргийн Боловсролын газрын мэргэжилтнүүд, Боловсрол, шинжлэх ухааны яамны холбогдох газрын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнд үндэслэн бичигдсэн болно.

6.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан багш, арга зүйчдийн ярьснаар 5 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор цэцэрлэгүүд дараах төсөл, үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

- Ном хөтөлбөр
- Уншлагын цаг-2021
- Номын богц
- Үлгэрийн баатрууд амилсан нь өдөрлөг
- Хөгжөөн баясгах цаг дээр ном уншиж өгөх
- Номтой нөхөрлөө
- “Үлгэр ярьж үлгэрлэн хүмүүжүүлье”
- Үлгэрч аав ээж

Дээрх үйл ажиллагааны заримыг хүүхдийг номтой нөхөрлүүлэх, номонд дуртай болгох зорилготой, тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.

Хүүхдийг номтой нөхөрлүүлэх, номонд дуртай болгох чиглэлээр нийслэл, дүүргээс олон ажлыг санаачлан зохион байгуулж байна. Тухайлбал, Нийслэлийн Боловсролын газраас 2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн бүх цэцэрлэгт “Номтой нөхөрлөө”, “Номын богц”, “Үлгэрч аав ээж” аяныг өрнүүлжээ. Тус аяны хүрээнд цэцэрлэгүүд “Нэг эцэг эх, нэг ном” уриа гаргаж эцэг эхчүүдээс цуглуулсан номоороо номын сангаа өргөжүүлсэн байна. Мөн эцэг эх хүүхэдтэйгээ хамт ном уншиж байгаагаа видео бичлэг болгон баримтжуулж, цэцэрлэгийн багш нарт илгээсэн байна. Цэцэрлэгийн хөгжөөн баясгах цагаар үлгэр, зохиолыг хүүхдэд танилцуулахдаа жүжигчилсэн тоглолт, сүүдэр жүжиг, хуруун хүүхэлдэй, хормогчны театр зэрэг олон аргыг ашиглажээ. Хүүхдүүд багш нарынхаа урьдчилан бэлтгэсэн гарын доорх материалыг ашиглан төрөл бүрийн жижиг ном хийсэн байна. Ном уншихын өмнө болон дараа нь хүүхдүүдээр зураг зуруулж, тухайн бүтээлээр нь үзэсгэлэн гаргасан байна.

Ийнхүү багш, эцэг эхчүүд хамтран хүүхдийг номонд дуртай болгох, номтой нөхөрлүүлэх санаачилгуудыг тодорхой аян, хөтөлбөрийн хүрээнд өрнүүлж байгаа ч номтой нөхөрлөснөөр хүүхдийн хөгжилд гарах эерэг өөрчлөлтийг үнэлэх, судлах арга зүй хангалттай бус байгааг судалгаанд оролцсон багш нар санал нэгтэй дурдаж байв.

6.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж буй сайн туршлагууд, сорилтууд

Эцэг эхчүүдийг хүүхдээ номоор дамжуулж хөгжүүлэхэд нь туслах ажлыг цэцэрлэгүүд тодорхой хэмжээнд зохион байгуулж байна. Оролцогч талууд, цэцэрлэг, олон улсын болон орон нутгийн захиргааны байгууллагууд сайн туршлагаа хуваалцдаг туршлага бий болсон байна.



Ишлэл 10. Боловсрол, шинжлэх ухааны яам

...Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох ажлыг санаачлан хэрэгжүүлж байгаа сайн туршлагууд олон бий. Энэ жилийн үндэсний хэмжээнд хэрэгжсэн хамгийн том, сайн туршлага гэвэл Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн 30-аад суманд Японы Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэй хэрэгжсэн төсөл юм. Энэ төсөл цэцэрлэг, сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд ном тоглоомын багц бэлтгэж, эцэг эхийнх нь дэмжлэгтэйгээр хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан. Энэ их үр дүнтэй ажил болсон. Бид энэ төслөө үндэсний хэмжээнд дахин өргөжүүлэн хэрэгжүүлээч гэж орон нутгийн захиргаанаас хүсээд байгаа.

Түүнчлэн эцэг эх, цэцэрлэгийн багш нар, мэргэжлийн хүмүүс оролцогч талуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгон ухамсарлаж, сайн туршлагаа харилцан солилцох нь үр дүнтэй гэдгийг гүнзгийрүүлсэн ярилцлагад хамрагдсан албаны хүмүүс онцолж байна.



Ишлэл 11. Нийслэлийн боловсролын газартай хийсэн ярилцлагаас

... 146 дугаар цэцэрлэг дээр эцэг эхчүүд өөрсдийн санаачилгаараа цэцэрлэгт ном хандивласан. Тэд нийлж байгаад эцэг эхийн танхим байгуулсан. Тэр танхимдаа хүүхдийн ном, гарын авлагуудыг байршуулаад, номоо солилцож уншдаг. Мөн Говь-Алтай аймагт цэцэрлэгт явах боломжгүй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулж номын боги ажиллуулж, буцаагаад хурааж авдаг. Дараа нь энэ аяныхаа талаар эцэг эхчүүдээс санал сэтгэгдлийг нь авдаг. Мөн цэцэрлэгүүд дээр явуулын багш нар ажиллаж байна. Дээрхтэй ижил хүүхдүүдэд ном уншиж өгөхийг дэмжих зорилгоор эцэг эхчүүдэд ном тарааж өгөөд, буцааж авдаг. Дундговь аймагт явуулын багш өрхүүдээр явж хүүхдүүдэд ном уншиж өгсөн сайн туршлага байна.



Ишлэл 12. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хийсэн ярилцлагаас

... Миний бодлоор эцэг эх рүү чиглэсэн ажлуудыг олон хийвэл үр дүнтэй гэж харж байна. Хэвлэл мэдээлэл, яам, бодлогын газрууд гээд олон талын хамтын ажиллагааг дэмжих хэрэгтэй. Олон улсын түвшинд бага наснаасаа эхлээд номыг уншиж сурах шаардлагатай гэж хий ярихаасаа илүү эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн төлөвшүүлэх, номтой нөхөрлүүлэх арга ухааныг зааж өгөх нь чухал. Мөн төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ талаар хөтөлбөр санаачилж буй Алтан загас гэдэг эмэгтэйд мэдэх юм байна. Бүтэн өгүүлбэрээр уншиж сургах ном гаргаж түүнийхээ сургалтад эцэг эхчүүдийг хамруулдаг. Саяхан сургалтад нь суухад аавуудын оролцоо сайжирсан байна. Эцэг эхчүүдэд энэ сургалт маш их таалагдсан байсан. Иймээс хамтарсан байдлаар соён гэгээрүүлэх ажлыг хийвэл үр дүнтэй. Мөн сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд эцэг эхээр дамжуулан боловсрол хүрнэ гэж итгэдэг.

Сургуулийн өмнөх боловсролын салбарын мэргэжилтнүүд хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эх, асран хамгаалагчид жигд бус оролцоотой байгааг чанарын судалгааны ярилцлагын үеэр дурдаж байсан бөгөөд цаашид тэднийг энэ үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулахад анхаарал хандуулахын чухлыг онцолж байв.

“

Ишлэл 13. Дүүргийн боловсролын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

... Цэцэрлэгийн хүүхэд гэр бүлтэйгээ хамт ном уншдаг тогтсон өдөртэй болбол их гоё. Тэр нь бүр компани ажил болоод тогтчихвол их сайн бөгөөд бодитойгоор хэрэгждэг байвал тун зүгээр санагддаг. Сүхбаатарын талбай дээр номын баяр болдог. Номын баяр дээр хүүхдийн номын хүртээмж ер нь хэр байна гээд харахад тун дажгүй санагдсан. Тиймээс үүн шиг хүүхдийн номын өдөрлөг зохион байгуулбал үр дүнтэй санагдсан.

Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход дан ганц эцэг эх, багш нар хичээж, олон чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулах бус хүүхдийг өөрийг нь энэ ажилд идэвхтэй оролцуулбал илүү үр өгөөжтэй байдгийг мэргэжлийн хүмүүс онцолж байв. Хүүхдүүд өөрсдөө ном бүтээх, өөрийн хийсэн бүтээлээрээ бахархах, бүтээсэн номоо хоорондоо солилцон уншвал хүүхдэд илүү сонирхолтой байж, тэдний цаашдын хөгжил төлөвшилд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

“

Ишлэл 14. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хийсэн ярилцлагаас

... Хүүхдүүд өөрсдөө цэцэрлэг дээрээ ном хийх, хийсэн номоо номын буландаа тавиад үздэг жишээ манай цэцэрлэгүүдэд зөндөө бий. Хүүхэд өөрийн болон найзуудынхаа хийсэн номыг үзэх сонирхолтой байдаг. Мөн “Номтой танилцсан нь” гэдэг фото зургийн үзэсгэлэнг цэцэрлэг дээр гаргавал их үр дүнтэй байх. Эцэг эх нь зөвхөн ном уншиж өгөөд байхгүй номоо сонсож байгаа, номынхоо тухай ярьж байгаа хүүхдийн нүүрний баясгаланг харуулсан фото зургуудаар танилцуулга хийж, цэцэрлэгийн ангиудын самбар дээр байрлуулбал их гоё болно. Энэ арга хэмжээг үндэсний олон нийтийн радио телевизээр сурталчилбал маш их үр дүнтэй болно. Миний санаж байгаагаар Ховдын цэцэрлэгийн эрхлэгч 2013 оноос хойш бэлтгэл бүлэг төгсөж байгаа бүх хүүхдүүдээрээ зураг зуруулж альбом, ном болгоод бүүр тогтчихсон.

6.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйлчилгээнээс хоцорч буй хүүхдүүдэд тухайн орон нутгийн захиргааны байгууллагаас болон боловсролын байгууллагаас хүрч буй байдал

Судалгааны хүрээнд баг, хорооны дарга, нийгмийн ажилтнууд болон боловсролын салбарын бодлогын түвшний мэргэжилтнүүдээс боловсролын үйлчилгээнээс хоцорсон, хоцрох эрсдэлтэй хүүхдүүд рүү чиглэж баг хорооны түвшинд хийгддэг үйл ажиллагааг тодруулсан. Хорооны засаг дарга, нийгмийн ажилтнуудын мэдээлж буйгаар орлого багатай, хараа хяналт султай хүүхдүүд боловсролын үйлчилгээнээс хоцорч, цэцэрлэгт хамралт хамгийн бага байна.

Боловсролын байгууллагын түвшинд, Сургуулийн өмнөх насны цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд явуулын хувилбарт сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. БШУЯ-аас харьяалалгүй буюу цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ хүргэх явуулын багшийг улсын хэмжээнд 972 цэцэрлэгт ажиллуулж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд багш нар хүүхэд хөгжлийн ухуулга, сурталчилгааны материалуудыг өрхийн эмнэлэг, банк зэрэг аль болох эцэг эхэд ойрхон байгууллагууд дээр аваачиж наах, хөтөлбөрт тусгагдаагүй олон нэмэлт ажлуудыг хийсэн байна. Хувилбарт сургалтын хүрээнд нь тухайн хүүхдийн хөгжлийн онцлогт тохируулсан сургалтын төлөвлөгөөгөөр сургагч багш нар долоо хоногт 4-5 цагийн хичээл ордог. Хувилбарт сургалтын үеэр сургагч багш нар эцэг эхчүүдэд арга зүйн зөвлөгөө өгч, хүүхдэдээ ном уншиж өгөх, номонд дуртай болгоход шаардлагатай арга зүйн зөвлөгөө өгч байна.

Дүүргийн түвшинд, хорооны нийгмийн ажилтан, хэлтсийн ахлагчид өрхийн бүртгэл хийхдээ цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийг бүртгэдэг ч улсын хэмжээнд нэгтгэсэн бүртгэл байхгүй байна. Бүртгэл дээрээ үндэслэн боловсролын үйлчилгээ үзүүлэх, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүдэд хамруулах боломжтой боловч албан ёсны харьяалал нь өөр газарт байдаг түр оршин суугч гэдэг үндэслэлээр ихэнх тохиолдолд эдгээр боломжийг хүртэж чаддаггүй байна.



Ишлэл 15. Сүхбаатар дүүргийн хорооны засаг даргатай хийсэн ярилцлагаас


... Манай хороонд нийт 28 нийтийн байр байна. 700 орчим хүн эдгээр байранд амьдардаг. Нийтийн байрны чанар хангалтгүй хэмжээнд байна. 12 метр квадратад 3-4 хүн амьдардаг гэж бодохоор хүүхдэд суралцах, чөлөөтэй тоглох орчин нөхцөл байдаггүй.

Ихэнх түр оршин суугчдын хувьд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, архины хамааралтай, зориулалтын бус байранд оршин суудаг өрхүүд байдаг ба тэдний хувьд хүүхдэд зориулсан номын хэсэг бий болгох, номтой танилцах, номонд дуртай болгох нь хязгаарлагдмал байдаг. Хорооны зүгээс чиг үүргийнхээ дагуу бүртгэл хийхээс хэтэрдэггүй байна. Учир нь ийм төрлийн ажлыг бие даан хийж зохион байгуулахад хүний нөөцийн чадавх болон цаг хугацаа, санхүүгийн бэрхшээл тулгарч байна.

Бүлгийн дүгнэлт

- Цэцэрлэгүүд өөрсдийн хязгаарлагдмал төсөвтөө тааруулан номоор дамжуулж хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанууд зохион байгуулдаг ч хүүхдийн номын хүртээмж, бэлэн байдал, номын чанар хангалтгүй хэвээр байна.
- Бага насны хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход эцэг эхчүүд, орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагууд хамтарч ажиллаж буй сайн жишээнүүд байна.
- Цэцэрлэгийн багш нар хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох эцэг эхийн оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой олон үйл ажиллагааг зохион байгуулж байна
- Цэцэрлэгүүд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлд эцэг эх, цэцэрлэгийн хамтын ажиллагааг сайжруулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Хэдий тийм ч нэгдсэн бодлогын дэмжлэг дутмаг байгаагаас эдгээр үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй зохион байгуулах тал хязгаарлагдмал байна.
- Боловсролын үйлчилгээнээс хоцрогдох эрсдэлтэй, хоцрогдсон хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ хүргэхэд орон нутгийн захиргааны болон боловсролын байгууллагуудын зүгээс холбогдох үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг зохион байгуулдаг ч хүртээмж, хамрагдалт харьцангуй бага байна. Үүний нэг шалтгаан нь түр оршин суугчдын харьяаллын асуудал гол нөлөө үзүүлж байна.

7. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ



- **Боловсрол, шинжлэх ухааны яам холбогдох бодлогын баримт бичгүүдэд хүүхдийг бага наснаас номонд дуртай болгохыг дэмжсэн зүйл заалт оруулах.** Судалгаанд хамрагдсан бодлого боловсруулагчид болон мэргэжлийн байгууллагын хүмүүсийн ярилцлагаас хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгоход чиглэсэн бодлого, эрх зүйн зохицуулалт дутмаг байна.
- **Боловсрол, шинжлэх ухааны яам бага насны хүүхдэд зориулсан номонд тавих нэгдсэн стандарт, шалгуурыг шинэчлэн батлах.** Худалдаанд буй хүүхдэд зориулсан номын агуулга, зураг, бичвэр нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирохгүй байх тохиолдол түгээмэл байна.
- Цэцэрлэгийн төсөвт хүүхдэд зориулсан ном худалдан авах зардлыг суулгаж өгөх. Цэцэрлэгүүд ном, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах санхүүжилт хангалтгүйгээс эцэг эхчүүдээс тусламж хүсэх замаар номын баяжилт хийж байна.
- **Хүүхдийг номтой танилцуулах, номонд дуртай болгох чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын салбарын байгууллага, гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах.** Цэцэрлэг, эцэг эх хүүхдийг номтой танилцах, нөхөрлөх, номонд дуртай болоход чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, сайн туршлага хуримтлуулж байгаа ч нэгдсэн зохицуулалт, бодлого, чиглэлтэй үйл ажиллагаа болон өргөжих, нэгж байгууллага, хувь хүмүүс хамтран ажиллах шаардлага байна.
- **Төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, цэцэрлэг, гэр бүл, эцэг эхчүүд туршлага солилцох хөдөлгөөн өрнүүлэх.** Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ярилцлагаас хүүхдийг номтой танилцуулах, номтой нөхөрлүүлэх чиглэлээр олон ажлыг санаачлан хийж буй ч хоорондоо туршлага солилцох, бие биеэсээ суралцах боломж хомс байна.
- **Бага насны хүүхэдтэй эцэг эх, цэцэрлэгийн багш нарт сургалт зохион байгуулах.** Ном унших нь хүүхдийн цаашдын хөгжил, төлөвшил, сурлагын амжилтад чухал үүрэгтэйг багш, эцэг эхэд сайтар ойлгуулах, хүүхдэдээ цаг зав гарган ном уншиж өгөх, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном сонгож авах зэрэг асуудлын хүрээнд сургалт зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах хэрэгцээ байна.
- **Боловсрол, шинжлэх ухааны яам хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хүүхдийг эхийн хэвлийд байхаас нь эхлэн ном уншиж өгөхийн ач холбогдлыг эцэг эх, олон нийтэд ойлгуулах мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах.** Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд нялх, балчир насанд (0-3 нас) ном уншиж өгөхийг чухалчлахгүй, зөвхөн сургуульд элсэхийн өмнө буюу 4-5 насанд нь номтой танилцуулах, ном уншиж өгөх хандлага байна.
- **Холбогдох боловсролын болон төрийн захиргааны байгууллагууд бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон агуулга, дизайнтай ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх.** Зах зээлд борлуулж буй хүүхдийн ном нь ихэвчлэн орчуулгын ном байна. Иймд монгол зохиолчдын дунд хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, цаашдын хөгжил, төлөвшилд хувь нэмэр оруулахуйц контент зохиох хөдөлгөөн өрнүүлэх хэрэгцээ шаардлага байна.
- **Цахим номын хэрэглээг нэмэгдүүлэх.** Судалгаанд хамрагдсан эцэг эх, багш нарын өгсөн мэдээллээс сургуулийн өмнөх насны хүүхдэд цахим ном уншиж өгөх дадал хэвшээгүй байгаа нь харагдлаа. Цахим номын хэрэглээг нэмэгдүүлэх нь хэвлэмэл ном худалдаж авах боломжгүй өрхийн эцэг эхчүүд хүүхдүүддээ ном уншиж өгөх боломж бүрдэх ач холбогдолтой юм.
- **Дүүрэг, хорооны байр, цэцэрлэгт номын өргөө байгуулах.** Хүүхдийн амьдарч буй

газрын ойролцоо номтой танилцах, ном үзэх боломж бүрдүүлбэл өрхийн орлого багатай хүүхдэд эцэг эх нь ном уншиж өгөх боломж бүрдэнэ.

- **Хувийн хэвшлийн байгууллагууд, жишээлбэл төрийн бус байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд өөрсдийн нөөц боломжид тулгуурлан бага насны хүүхэд ном үзэх, үлгэр зохиол сонсох орчин бүрдүүлсэн бичил номын сан, уншлагын танхим байгуулах санаачилга өрнүүлэх.** Монгол улсад нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн хөгжил, төлөвшилд хувь нэмэр оруулах, хүүхдийг номтой танилцах боломж олгосон сайн санаачилгууд байгаа ч төдийлөн өргөн хүрээнд тархаагүй байна. Жишээ нь, Монгол Австралийн нийгэмлэгийн гишүүд сайн дураараа хөрөнгө босгож, Соёлын төв өргөөнд нэг ерөөг тохижуулан хүүхэд ном унших, үлгэр сонсох боломжтой бичил орчин бүрдүүлэн ажиллуулж байгаа шиг сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй байна.
- **Хувийн хэвшлийн байгууллагууд, жишээлбэл төрийн бус байгууллагууд гэр бүл олон нийт өөрийн хүүхдийн хэрэглэхгүй болсон ном, үлгэр зэргийг нэг дор цуглуулан ном худалдан авах боломжгүй айл өрхийн хүүхдэд номтой танилцах боломж олгосон орчин нөхцөл бүрдүүлэх хөдөлгөөн өрнүүлэх.**
- **Хувийн хэвшлийн номын дэлгүүрүүд хүүхэд ном үзэх, үлгэр сонсох боломжтой булан гаргаж, тохижуулах.** Энэ буланд ном худалдан авах боломжгүй өрхийн эцэг эхчүүд хүүхдэдээ ном уншиж өгөх, зураг үзүүлэх, хүүхэдтэйгээ харилцан ярилцах боломж бүрдэх сайн талтай.

ХАВСРАЛТ

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл			
Бүгд		Давтамж	Хувь
		838	100.0
Дүүрэг	Баянгол дүүрэг	130	15.5%
	Баянзүрх дүүрэг	206	24.6%
	Налайх дүүрэг	37	4.4%
	Сонгинохайрхан дүүрэг	192	22.9%
	Сүхбаатар дүүрэг	74	8.8%
	Хан-Уул дүүрэг	118	14.1%
	Чингэлтэй дүүрэг	81	9.7%
2.1 Судалгаанд оролцогчийн хүйс	Эрэгтэй	198	23.6%
	Эмэгтэй	640	76.4%
2.2 Судалгаанд оролцогчийн нас	20 хүртэл	19	2.3%
	21-25	79	9.4%
	26-30	183	21.8%
	31-35	196	23.4%
	36-40	159	19.0%
	41-45	92	11.0%
	46-50	47	5.6%
	51+	63	7.5%
2.3 Судалгаанд оролцогчийн боловсролын түвшин	Боловсролгүй	0	0.0%
	Сургуулийн өмнөх	0	0.0%
	Бага	5	0.6%
	Суурь	52	6.2%
	Бүрэн дунд	298	35.6%
	Техник мэргэжлийн	12	1.4%
	Тусгай дунд /техникум/	28	3.3%
	Дипломын дээд	18	2.1%
	Бакалавр	357	42.6%
	Магистр	61	7.3%
Доктор	7	0.8%	
2.4 Гэр бүлийн гишүүдийн эзэмшсэн хамгийн өндөр боловсролын түвшин	Боловсролгүй	0	0.0%
	Сургуулийн өмнөх	0	0.0%
	Бага	2	0.2%
	Суурь	16	1.9%
	Бүрэн дунд	182	21.7%
	Техник мэргэжлийн	17	2.0%
	Тусгай дунд /техникум/	22	2.6%
	Дипломын дээд	23	2.7%
	Бакалавр	429	51.2%
	Магистр	131	15.6%
Доктор	16	1.9%	

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

2.5 Хамгийн өндөр боловсролтой хүн нь хүүхэдтэй ямар хамааралтай вэ?	Өрхийн тэргүүн	113	13.5%
	Эхнэр/Нөхөр	165	19.7%
	Хүү/Охин	15	1.8%
	Эцэг эх	466	55.6%
	Ах/Эгч	32	3.8%
	Хадам аав/Хадам ээж	0	0.0%
	Хадам ах/Хадам дүү	0	0.0%
	Өвөө/Эмээ	38	4.5%
	Ач хүү/Ач охин	2	0.2%
	Бусад хамаатан	3	0.4%
	Бусад	4	0.5%
	2.6 Судалгаанд оролцогчийн гэрлэлтийн байдал	Огт гэрлээгүй	51
Гэрлэсэн: Батлуулсан		551	65.8
Гэрлэсэн: Батлуулаагүй		215	25.7
Тусдаа амьдардаг		3	0.4
Гэрлэлт цуцалсан		6	0.7
Бэлэвсэн		12	1.4

Өрхийн мэдээлэл

		Давтамж	Хувь
		838	100.0%
2.8 Танай гэр бүл ямар сууцанд амьдардаг вэ?	Бүгд		
	Гэр	163	19.5%
	Хашаа байшин	262	31.3%
	Орон сууц	403	48.1%
	Бие даасан тохилог сууц	9	1.1%
2.9 Өрхийн жилийн орлого	Бусад /тодруулах/	1	0.1%
	3.6 сая хүртэл	27	3.2%
	3.6-6 сая	26	3.1%
	6-8.4 сая	47	5.6%
	8.4-10.8 сая	73	8.7%
	10.8-13.2 сая	154	18.4%
	13.2-19.2 сая	190	22.7%
	19.2-25.2 сая	147	17.5%
25.2-оос дээш сая	174	20.8%	
2.10 Өрхийн орлогын хүрэлцээ	Ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй (хоол хүнс, орон байр гэх мэт)	126	15.0%
	Ойр зуурын хэрэгцээнд л хүрдэг. Гэхдээ хуримтлал үүсгэж чаддаггүй	498	59.4%
	Ойр зуурын хэрэгцээ, хувцас эд зүйл авахад хангалттай хүрэлцдэг	97	11.6%
	Ойр зуурын хэрэгцээнд хүрэлцэхээс гадна тансаг эд зүйл авдаг	13	1.6%
	Ойр зуурын хэрэгцээнд хүрэлцэхээс гадна хадгаламж үүсгэж чаддаг	104	12.4%

Сонгогдсон хүүхдийн мэдээлэл

	Бүгд	Давтамж	Хувь
		838	100.0%
2.11 Ам бүлийн тоо Сүүлийн 6 сарын хугацаанд тухайн өрхөд хамт амьдарч буй хүмүүсийн тоо	3 хүртэл	112	13.4%
	4-5	475	56.7%
	6+	251	30.0%
2.12 Үүнээс 0-5 насны хүүхдийн тоо	1	533	63.6%
	2	257	30.7%
	3	44	5.3%
	4	4	0.5%
2.13 Сонгогдсон хүүхдийн нас	1 наснаас бага	71	8.5%
	1	122	14.6%
	2	135	16.1%
	3	135	16.1%
	4	168	20.0%
	5	207	24.7%
2.14 Судалгаанд сонгогдсон хүүхдийн хүйс	Эрэгтэй	445	53.1%
	Эмэгтэй	393	46.9%
2.15 Таны хүүхэд цэцэрлэгт хэр удаан явсан бэ?	Огт явж байгаагүй	305	36.4%
	1 жил хүртэлх	154	18.4%
	2 жил	155	18.5%
	3 жил	171	20.4%
	4 жил	53	6.3%
2.16 Таны хүүхэд хүүхэд харах үйлчилгээнд хэр удаан хамрагдсан бэ?	Огт явж байгаагүй	782	93.3%
	1 жил хүртэлх	35	4.2%
	2 жил	11	1.3%
	3 жил	7	0.8%
	4 жил	3	0.4%
2.17 Танай өрхөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бий юу?	Тийм	19	2.3%
	Үгүй	819	97.7%
2.18 Сонгогдсон хүүхдэд гэр бүлийн аль гишүүн ном уншиж өгдөг вэ?			
Ээж	Өдөр бүр	106	12.6%
	7 хоногт 1-2 удаа	304	36.3%
	Сард 1-2 удаа	226	27.0%
	Огт уншиж өгдөггүй	187	22.3%
	N/A	15	1.8%
Аав	Өдөр бүр	33	3.9%
	7 хоногт 1-2 удаа	145	17.3%
	Сард 1-2 удаа	177	21.1%
	Огт уншиж өгдөггүй	412	49.2%
	N/A	71	8.5%

Сонгогдсон хүүхдийн мэдээлэл

Ах/эгч	Өдөр бүр	34	4.1%
	7 хоногт 1-2 удаа	75	8.9%
	Сард 1-2 удаа	71	8.5%
	Огт уншиж өгдөггүй	151	18.0%
	N/A	507	60.5%
Өвөө/Эмээ	Өдөр бүр	71	8.5%
	7 хоногт 1-2 удаа	122	14.6%
	Сард 1-2 удаа	135	16.1%
	Огт уншиж өгдөггүй	135	16.1%
	N/A	168	20.0%
Бусад	Өдөр бүр	445	53.1%
	7 хоногт 1-2 удаа	393	46.9%
	Сард 1-2 удаа	305	36.4%
	Огт уншиж өгдөггүй	154	18.4%
	N/A	155	18.5%
2.17 Таны хүүхэд хүүхэд харах үйлчилгээнд хэр удаан хамрагдсан бэ?	Огт явж байгаагүй	2	0.3%
	1 жил хүртэлх	2	0.3%
	2 жил	2	0.3%
	3 жил	26	4.3%
	4 жил	575	94.7%
2.18 Танай өрхөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бий юу?	Тийм	19	2.3%
	Үгүй	819	97.7%

Эцэг эх, асран хамгаалагчдын ном унших дадал

Бүгд		Давтамж	Хувь
		838	100.0
3.1.1 Би хүүхдийнхээ дэргэд ном уншдаг бөгөөд миний уншиж байгааг хүүхэд маань хардаг.	Өдөр бүр	83	9.9%
	7 хоногт 1-2 удаа	269	32.1%
	Сард 1-2 удаа	266	31.7%
	Огт үгүй	220	26.3%
3.1.2 Би хүүхдэдээ ном харахгүйгээр үлгэр ярьж өгдөг.	Өдөр бүр	85	10.1%
	7 хоногт 1-2 удаа	312	37.2%
	Сард 1-2 удаа	231	27.6%
	Огт үгүй	210	25.1%
3.1.3 Би хүүхдийнхээ яриаг анхааралтай сонсдог бөгөөд харилцан ярилцдаг.	Өдөр бүр	636	75.9%
	7 хоногт 1-2 удаа	110	13.1%
	Сард 1-2 удаа	41	4.9%
	Огт үгүй	51	6.1%
3.1.4 Би хүүхдэдээ ном уншиж өгдөг	Өдөр бүр	81	9.7%
	7 хоногт 1-2 удаа	317	37.8%
	Сард 1-2 удаа	261	31.1%
	Огт үгүй	179	21.4%
3.1.5 Би хүүхдийнхээ дэргэд санаа зовохгүйгээр номыг чанга уншдаг.	Маш их санаа зовдог	8	1.0%
	Бага зэрэг санаа зовдог	86	10.3%
	Санаа зовдоггүй	453	54.1%
	Огт санаа зовдоггүй	291	34.7%
3.1.6 Танай гэртэй ойрхон номын дэлгүүр бий юу ?	Тийм	180	21.5%
	Үгүй	644	76.8%
	Мэдэхгүй	14	1.7%
3.1.7 Би ном авч өгөхөөр хүүхэдтэйгээ хамт номын дэлгүүр явдаг .	Өдөр бүр	0	0.0%
	7 хоногт 1-2 удаа	21	2.5%
	Сард 1-2 удаа	266	31.7%
	Огт үгүй	551	65.8%
3.1.8 Танай гэртэй ойрхон номын сан бий юу ?	Тийм	111	13.2%
	Үгүй	712	85.0%
	Мэдэхгүй	15	1.8%
3.1.9 Би ном үзүүлэхээр хүүхэдтэйгээ хамт номын сан явдаг .	Өдөр бүр	2	0.2%
	7 хоногт 1-2 удаа	9	1.1%
	Сард 1-2 удаа	75	8.9%
	Огт үгүй	752	89.7%

Эцэг эх, асран хамгаалагчдын ном унших дадал

Бүгд		Давтамж	Хувь
		838	100.0
3.1.10 Би номын зургийг хүүхдэдээ харуулаад түүний тухай ярилцдаг	Хэзээ ч үгүй	105	12.5%
	Ховорхон	139	16.6%
	Заримдаа	287	34.2%
	Ихэнхдээ	171	20.4%
	Байнга	136	16.2%
3.1.11 Би хүүхдэдээ номны үг, үсгийг нь заан уншиж өгдөг	Хэзээ ч үгүй	304	36.3%
	Ховорхон	115	13.7%
	Заримдаа	222	26.5%
	Ихэнхдээ	110	13.1%
	Байнга	87	10.4%
3.1.12 Ном уншиж өгөх үед хүүхэд сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэхийг би дэмждэг.	Хэзээ ч үгүй	105	12.5%
	Ховорхон	61	7.3%
	Заримдаа	152	18.1%
	Ихэнхдээ	199	23.7%
	Байнга	321	38.3%
3.1.13 Би хүүхэдтэйгээ хамт бүтээгдэхүүний шошго, гудамжны самбарын тэмдэглэгээг уншдаг.	Хэзээ ч үгүй	286	34.1%
	Ховорхон	78	9.3%
	Заримдаа	196	23.4%
	Ихэнхдээ	98	11.7%
	Байнга	180	21.5%
3.1.14 Ном уншиж өгөх үедээ хүүхдийн сонирхлыг татахын тулд нүүрний хувирал ба дуу хоолойны өнгөө өөрчилдөг.	Хэзээ ч үгүй	225	26.8%
	Ховорхон	71	8.5%
	Заримдаа	189	22.6%
	Ихэнхдээ	124	14.8%
	Байнга	229	27.3%
3.1.15 Хүүхэд ном үзэх үед үсэг, тоог хуруугаар нь заалгадаг.	Хэзээ ч үгүй	224	26.7%
	Ховорхон	86	10.3%
	Заримдаа	197	23.5%
	Ихэнхдээ	156	18.6%
	Байнга	175	20.9%
3.1.16 Номонд дуртай болгох тоглоом хүүхэдтэйгээ хамт тоглодог.	Хэзээ ч үгүй	336	40.1%
	Ховорхон	99	11.8%
	Заримдаа	206	24.6%
	Ихэнхдээ	91	10.9%
	Байнга	106	12.6%
3.1.17 Хүүхэд ном уншиж өгөхдөө тухайн дүрийн онцлогийг дуу хоолойгоор илэрхийлдэг.	Хэзээ ч үгүй	234	27.9%
	Ховорхон	79	9.4%
	Заримдаа	203	24.2%
	Ихэнхдээ	131	15.6%
	Байнга	191	22.8%

Эцэг эх, асран хамгаалагчдын ном унших дадал			
3.1.18 Би ном уншиж өгөхдөө хүүхдээсээ олон асуулт асуудаг.	Хэзээ ч үгүй	286	34.1%
	Ховорхон	80	9.5%
	Заримдаа	229	27.3%
	Ихэнхдээ	107	12.8%
	Байнга	136	16.2%
3.1.19 Хүүхэд Монгол болон гадаад үгсийг ойлгохгүй бол би тайлбарлаж өгдөг.	Хэзээ ч үгүй	260	31.0%
	Ховорхон	51	6.1%
	Заримдаа	178	21.2%
	Ихэнхдээ	142	16.9%
	Байнга	207	24.7%

Гурав. Эцэг эхчүүдийн хүүхдэд ном унших арга барил, үргэлжлэх хугацаа			
Нийт хүүхдэдээ ном уншиж өгдөг эцэг эхийн тоо		Давтамж	Хувь
		838	100.0
3.2 Та хүүхдэдээ 1 удаа ном уншиж өгөхдөө хэр их хугацаа зарцуулдаг вэ ?	10 минут хүртэл	172	26.1%
	10-20 минут	260	39.5%
	20-30 минут	177	26.9%
	30 минутаас их	50	7.6%
3.3 Та хүүхдэдээ ямар үед ном уншиж өгдөг вэ?	Хүүхдийг хүссэн үед	287	43.6%
	Шинэ ном худалдаж авсан үедээ	258	39.2%
	Шаардлагатай үед	76	11.5%
	Завтай үедээ	320	48.6%
	Хүүхэд уйдсан үед	69	10.5%
	Унтахынхаа өмнө	296	44.9%
	Хүүхдээ найзуудтай нь тоглож байх үед	12	1.8%
	Бусад	5	0.8%
3.4 Та хүүхдэдээ ихэвчлэн номыг яаж уншиж өгдөг вэ? Хамгийн олон удаа тохиолддог 3 хүртэлх хувилбарыг сонгоно уу	Зургийг хараад ярилцдаг.	515	78.1%
	Тухайн үлгэрийн талаар асуулт асуудаг.	237	36.0%
	Үсэгнүүдийг зааж, ярилцдаг.	97	14.7%
	Зураг дээрх зүйлсийг тоолдог.	188	28.5%
	Хүүхэд үлгэрийн аль нэг хэсгийг дуурайхад нь урамшуулан дэмждэг.	152	23.1%
	Үлгэрийн дүрийг жүжигчлэн тоглохыг дэмждэг.	105	15.9%
	Дээрхийн аль нь ч биш. Саад болохгүйгээр өөрөөр нь уншуулдаг.	19	2.9%
	Бусад	33	5.0%

		Давтамж	Хувь
		838	100.0
4.1 Та номыг хэр сонирхож уншдаг вэ? Өөрийн сонирхлыг үнэлнэ үү.	Маш их сонирхдог	124	14.8%
	Их сонирхдог	245	29.2%
	Дунд зэрэг сонирхдог	277	33.1%
	Бага сонирхдог	120	14.3%
	Бараг сонирхдоггүй	72	8.6%
4.2 Таны хүүхэд номыг хэр сонирхдог вэ?	Маш их сонирхдог	135	16.1%
	Их сонирхдог	297	35.4%
	Дунд зэрэг сонирхдог	243	29.0%
	Бага сонирхдог	99	11.8%
	Бараг сонирхдоггүй	64	7.6%
4.2.1 Таны хүүхэд номонд дуртай байгаа шалтгаан юу вэ?	Би түүнд ном уншиж өгдөг учраас	269	22.0%
	Манайх гэртээ номын сантай учраас	118	9.7%
	Манай гэр бүлийн гишүүд их ном уншдаг учраас	185	15.2%
	Бид түүний хүссэн номыг нь худалдаж авч өгдөг учраас	216	17.7%
	Цэцэрлэгт багш нар нь ном уншиж өгдөг учраас	257	21.1%
	Ном уншихтай холбоотой даалгавар их өгдөг учраас	42	3.4%
	Найзууд нь их уншдаг учраас	14	1.1%
	Бусад	86	7.0%
4.2.2 Таны хүүхэд номонд дургүй байгаагийн шалтгаан юу вэ?	Мэдэхгүй	33	2.7%
	Бид хүүхдэдээ ном тогтмол уншиж өгдөггүй учраас	46	20.2%
	Манай гэрт хангалттай ном байдаггүй учраас	28	12.3%
	Гэр бүлийн гишүүд нэг их уншдаггүй учраас	29	12.7%
	Бид хүүхдэдээ ном худалдаж авч өгдөггүй учраас	17	7.5%
	Цэцэрлэгт багш нар нь ном уншиж өгдөггүй учраас	2	0.9%
	Найзууд нь ном уншдаггүй учраас	5	2.2%
	Бусад	91	39.9%
4.12.1. Танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө	Мэдэхгүй	10	4.4%
	Огт санал нийлэхгүй	42	2.1
	Санал нийлэхгүй	434	29.3
	Дундаж	136	9.2
	Санал нийлнэ	319	21.6
	Бүрэн санал нийлнэ	168	11.4
Мэдэхгүй	148	10.0	

4.3 Миний хүүхэд үсэгтэй тоглоомоор тоглох боломжтой байдаг	Хэзээ ч үгүй	192	22.9%
	Ховорхон	139	16.6%
	Заримдаа	200	23.9%
	Ихэнхдээ	134	16.0%
	Байнга	173	20.6%
4.4 Хүүхэд ном уншиж өгөхийг надаас хүсдэг	Хэзээ ч үгүй	176	21.0%
	Ховорхон	81	9.7%
	Заримдаа	270	32.2%
	Ихэнхдээ	168	20.0%
	Байнга	143	17.1%
4.5 Хүүхэд ном уншиж байгаа дүр эсгэж, үлгэр ярьдаг.	Хэзээ ч үгүй	186	22.2%
	Ховорхон	67	8.0%
	Заримдаа	274	32.7%
	Ихэнхдээ	163	19.5%
	Байнга	148	17.7%
4.6 Хүүхэд гадаа зугаалах үед гудамжны самбарын тэмдгийг зааж, сонирхож байгаагаа илэрхийлдэг.	Хэзээ ч үгүй	180	21.5%
	Ховорхон	66	7.9%
	Заримдаа	216	25.8%
	Ихэнхдээ	163	19.5%
	Байнга	213	25.4%
4.7 Хүүхэд номоор тоглох, өөрөө ном унших дуртай	Хэзээ ч үгүй	133	15.9%
	Ховорхон	73	8.7%
	Заримдаа	228	27.2%
	Ихэнхдээ	206	24.6%
	Байнга	198	23.6%
4.8 Таныг ном уншиж өгөх үед хүүхэд юуг нь илүү сонирхдог вэ?	Зураг	499	35.6%
	Агуулга	109	7.8%
	Үсэг	35	2.5%
	Өнгө	300	21.4%
	Дүрс	272	19.4%
	Тоглоом	175	12.5%
	Бусад	13	0.9%
4.9 Таныг ном уншиж өгөх үед хүүхэд тань дуустал анхааралтай сонсож чаддаг уу?	Дуустал нь анхааралтай сонсдог	185	22.1%
	Ихэнх хэсгийг анхааралтай сонсдог	192	22.9%
	Багахан хэсгийг л анхаардаг	216	25.8%
	Огт анхаардаггүй	66	7.9%
4.10 Таны бодлоор хүүхдийг хэдэн наснаас эхлэн номтой танилцуулах хэрэгтэй вэ?	Эхийн хэвлийд байх үеэс	95	11.3%
	0-2 нас	327	39.0%
	3-5 нас	351	41.9%
	6-7 нас	51	6.1%
	7-оос дээш нас	14	1.7%
4.11.1. Эцэг эхчүүд хүүхэдээ ном уншиж өгөх нь чухал	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Зарим талаараа санал нийлэхгүй	7	0.8%
	Дундаж	43	5.1%
	Зарим талаараа санал нийлнэ	196	23.4%
	Маш их санал нийлнэ	591	70.5%

4.11.2. Эцэг, эхчүүд гэртээ ном сайн уншуулдаг учраас тэд сургууль дээрээ сайн уншдаг	Огт санал нийлэхгүй	15	1.8%
	Зарим талаараа санал нийлэхгүй	20	2.4%
	Дундаж	82	9.8%
	Зарим талаараа санал нийлнэ	240	28.6%
	Маш их санал нийлнэ	481	57.4%
4.11.3. Эцэг эхчүүд хүүхдэдээ унших болон бичих чадвартай болоход туслах үүрэгтэй	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Зарим талаараа санал нийлэхгүй	4	0.5%
	Дундаж	16	1.9%
	Зарим талаараа санал нийлнэ	148	17.7%
	Маш их санал нийлнэ	669	79.8%
4.11.4. Эцэг эхчүүд агуулга нь сонирхолтой, эх хэлээр зөв бичигдсэн, өнгөлөг ном сонгох хэрэгтэй	Огт санал нийлэхгүй	3	0.4%
	Зарим талаараа санал нийлэхгүй	8	1.0%
	Дундаж	37	4.4%
	Зарим талаараа санал нийлнэ	203	24.2%
	Маш их санал нийлнэ	587	70.0%
4.11.5. Үеэр тасалж унших хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд эцэг эх туслах ёстой	Огт санал нийлэхгүй	6	0.7%
	Зарим талаараа санал нийлэхгүй	3	0.4%
	Дундаж	23	2.7%
	Зарим талаараа санал нийлнэ	136	16.2%
	Маш их санал нийлнэ	670	80.0%
4.11.6. Өөрийн санаа бодлыг цаасан дээр зургаар илэрхийлэх хүсэл, сонирхолтой байх, өөртөө итгэлтэй болоход туслах хэрэгтэй	Огт санал нийлэхгүй	0	0.0%
	Зарим талаараа санал нийлэхгүй	4	0.5%
	Дундаж	15	1.8%
	Зарим талаараа санал нийлнэ	144	17.2%
	Маш их санал нийлнэ	675	80.5%
4.11.7. Хүүхдээ унших сонирхолтой болгох нь маш чухал	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Зарим талаараа санал нийлэхгүй	2	0.2%
	Дундаж	25	3.0%
	Зарим талаараа санал нийлнэ	107	12.8%
	Маш их санал нийлнэ	703	83.9%
4.11.8. Сургууль дээр заасан тоолох, уншиж бичих дасгал, даалгаврыг эцэг, эхчүүд гэрт нь давтуулах хэрэгтэй	Огт санал нийлэхгүй	2	0.2%
	Зарим талаараа санал нийлэхгүй	3	0.4%
	Дундаж	29	3.5%
	Зарим талаараа санал нийлнэ	127	15.2%
	Маш их санал нийлнэ	677	80.8%
4.11.9. Эцэг эхчүүд хүүхдүүддээ ном унших нь сонирхолтой зүйл гэдгийг ойлгуулах хэрэгтэй	Огт санал нийлэхгүй	0	0.0%
	Зарим талаараа санал нийлэхгүй	3	0.4%
	Дундаж	22	2.6%
	Зарим талаараа санал нийлнэ	147	17.5%
	Маш их санал нийлнэ	666	79.5%

Дөрөв. Хүүхэд, эцэг эхийн ном унших сонирхол; Хүүхдэд ном уншихын ач холбогдлын талаарх эцэг эхчүүдийн мэдлэг

4.12.1. Танин мэдэхүйн хөгжилд эергээр нөлөөлнө	Огт санал нийлэхгүй	5	0.6%
	Санал нийлэхгүй	6	0.7%
	Дундаж	27	3.2%
	Санал нийлнэ	139	16.6%
	Бүрэн санал нийлнэ	649	77.4%
	Мэдэхгүй	12	1.4%
4.12.2. Нийгэмшихүйн хөгжилд нөлөөлнө	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Санал нийлэхгүй	11	1.3%
	Дундаж	61	7.3%
	Санал нийлнэ	210	24.1%
	Бүрэн санал нийлнэ	546	65.2%
	Мэдэхгүй	9	1.1%
4.12.3. Сургуульд амжилттай сурахад нөлөөлнө.	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Санал нийлэхгүй	8	1.0%
	Дундаж	35	4.2%
	Санал нийлнэ	170	20.3%
	Бүрэн санал нийлнэ	615	73.4%
	Мэдэхгүй	9	1.1%
4.12.4. Эцэг эх, асран хамгаалагчтайгаа ойр дотно болно	Санал нийлэхгүй	12	1.4%
	Дундаж	53	6.3%
	Санал нийлнэ	210	25.1%
	Бүрэн санал нийлнэ	545	65.0%
	Мэдэхгүй	11	1.3%
4.12.5. Хэл ярианы хөгжил нь сайжирна	Огт санал нийлэхгүй	1	0.1%
	Санал нийлэхгүй	3	0.4%
	Дундаж	17	2.0%
	Санал нийлнэ	115	13.7%
	Бүрэн санал нийлнэ	694	82.8%
	Мэдэхгүй	8	1.0%
4.13 Та ямар нэгэн номын клубт гишүүнчлэлтэй юу?	Тийм	114	13.6%
	Үгүй	724	86.4%

Номын хүртээмж		Frequency	Percent
		838	100.0
5.1 Миний хүүхдэд 1 ширхэг цагаан толгойн ном бий	Үнэн	443	52.9%
	Худал	395	47.1%
5.2 Танай гэрт хэдэн ном байгаа вэ?	1-5	142	16.9%
	6-15	205	24.5%
	16-20	112	13.4%
	20-оос дээш	379	45.2%
5.3 Хүүхэд гэртээ жимс, тээврийн хэрэгсэл, амьтад гэх мэт зүйлстэй танилцах тоглоомоор тоглодог	Огт тоглодоггүй	45	5.4
	Бараг тоглодоггүй	67	8.0
	Дунд зэрэг тоглодог	679	81.0
	Хангалттай тоглодог	159	19.0
	Маш их тоглодог	85	10.1
5.4 Гэрт ном тоглоомнууд нь зориулалтын газар байдаг	Тийм	679	81.0%
	Үгүй	159	19.0%
5.5 Ном, тоглоомууд нь хүүхдэд хүртээмжтэй байдаг	Тийм	665	79.4%
	Үгүй	173	20.6%
5.6 Бид ном худалдаж авахад мөнгө зарцуулдаг	Тийм, үргэлж	194	23.2%
	Тийм, Хааяа	553	66.0%
	Үгүй	91	10.9%
5.7 Бид хүүхдийн ном худалдаж авахад мөнгө зарцуулдаг	Тийм, үргэлж	209	24.9%
	Тийм, Хааяа	512	61.1%
	Үгүй	26	3.1%
5.7 Бид хүүхдийн ном худалдаж авахад мөнгө зарцуулдаг	Тийм, үргэлж	209	24.9%
	Тийм, Хааяа	512	61.1%
	Үгүй	26	3.1%
5.8 Хэрвээ та хүүхдийн ном худалдаж авах бол юуг чухалчлан үзэх вэ ?	Үнэ боломжийн байх	174	8.6%
	Хүүхдийн насны онцлогт тохирсон байх	635	31.3%
	Бичвэр багатай, зураг ихтэй байх	341	16.8%
	Хатуу хавтастай байх	163	8.0%
	Зөөлөн хавтастай байх	40	2.0%
	Монгол зохиолчтой байх	103	5.1%
	Гадаад зохиолчтой байх	13	0.6%
	Гадаад зурагтай	8	0.4%
	Монгол зурагтай	107	5.3%
	Хүүхдийн сонирхолд нийцсэн байх	343	16.9%
	Хэлний сонголттой байх Англи/Монгол/Орос/Солонгос	57	2.8%
	Бусад	42	2.1%

Номын хүртээмж			
5.9 Хүүхдийнхээ насны онцлогт тохирсон ном худалдан авахад танд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Ойр номын дэлгүүр байдаггүй	434	29.3%
	Санхүүгийн боломжгүй	136	9.2%
	Ном хэтэрхий их үнэтэй	319	21.6%
	Ном дэлгүүрт сонирхсон ном байдаггүй	168	11.4%
	Монгол хүүхдийн сэтгэхүйд тохирсон ном байхгүй	148	10.0%
	Миний хүүхдийн сонирхолд нийцсэн ном байхгүй	143	9.7%
	Бусад	132	8.9%
5.10 Танай гэрт хүүхэд насанд хүрсэн хүний тусламжгүйгээр номонд хүрэх боломж хэр их байдаг вэ ?	Ямар ч саадгүй хүрэх боломжтой	367	43.8%
	Боломжтой	247	29.5%
	Тодорхой хэмжээнд хүрэх боломжтой	60	7.2%
	Бараг хүрэх боломжгүй	81	9.7%
	Огт хүрэх боломжгүй	83	9.9%
5.11.1 Танай хүүхэд цэцэрлэг/өдөр өнжүүлэх дээрээ насанд хүрсэн хүний тусламжгүйгээр номонд хүрэх боломжтой байдаг уу ?	Тийм	679	81.0%
	Үгүй	159	19.0%
	Мэдэхгүй	665	79.4%
5.12 Номын сан танай гэрт хэр ойрхон байна вэ ?	Маш ойрхон (15 минутын зайтай)	85	10.1%
	Хажууд (16-30 минутын зайтай)	114	13.6%
	Хол (31 минутаас-1 цагийн зайтай)	239	28.5%
	Маш хол (1 цаг гаруйн зайд)	373	44.5%
	Мэдэхгүй	12	1.4%
5.13 Таны хүүхэд насанд хүрэгчдийн тусламжгүйгээр ихэвчлэн хаана номтой ойр байдаг вэ?	Гэртээ	636	75.9%
	Цэцэрлэг дээрээ	175	20.9%
	Хүүхэд харах үйлчилгээний төвд	2	0.2%
	Баг, хорооны нутаг дэвсгэрийн байгууллага, төвүүд	1	0.1%
	Бусад	24	2.9%
5.14 Хүүхдэд зориулсан ном ямар хэл дээр илүү олдоцтой байдаг вэ?	Монгол	628	74.9%
	Англи	173	20.6%
	Орос	12	1.4%
	Бусад	25	3.0%
5.15 Та хүүхдийн номын ямар хэлбэрийг хамгийн их ашиглах боломжтой вэ ?	Хэвлэмэл ном	749	89.4%
	Дижитал/цахим ном	89	10.6%
5.16 Та хүүхдүүдтэйгээ ямар төрлийн ном ашиглахыг илүүд үздэг вэ ?	Хэвлэмэл	732	87.4%
	Дижитал/цахим	54	6.4%
	Аль аль нь	52	6.2%
5.17. Та хүүхдэдээ хэвлэмэл номыг хэрхэн авч үзүүлдэг вэ ?	Худалдаж авч өгдөг	768	91.6%
	Зээлдэг	17	2.0%
	Бусад	53	6.3%

Номын хүртээмж			
		Frequency	Percent
		838	100.0
5.18. Та хүүхдэдээ дижитал/цахим номыг хэрхэн авч үзүүлдэг вэ ?	Худалдаж авч өгдөг	104	12.4%
	Зээлдэг	5	0.6%
	Авч өгдөггүй	702	83.8%
	Бусад	27	3.2%

6.1 Танайд 1, 2 дугаар ангийн сурагч бий юу?	Тийм	203	24.2%
	Үгүй	635	75.8%
6.2 Та хүүхдээ сургуульд орохоос нь өмнө хэр их ном уншиж өгдөг байсан бэ?	Хэзээ ч үгүй	12	140.0%
	Ховорхон	48	570.0%
	Заримдаа	81	970.0%
	Ихэнхдээ	43	510.0%
	Байнга	19	230.0%
6.3.1. Танин мэдэхүйн хөгжилд	Маш чухал	92	11.0%
	Чухал	51	6.1%
6.3.2. Хэл ярианы хөгжилд	Маш чухал	85	10.1%
	Чухал	56	6.7%
	Бага зэрэг чухал	2	0.2%
6.3.3. Нийгэмшихүйн хөгжилд	Маш чухал	57	6.8%
	Чухал	78	9.3%
	Бага зэрэг чухал	8	1.0%
6.3.4. Анхаарал төвлөрөлтөд	Маш чухал	80	9.5%
	Чухал	61	7.3%
	Бага зэрэг чухал	1	0.1%
	Мэдэхгүй	1	0.1%
6.3.5. Харилцааны ур чадварт	Маш чухал	72	8.6%
	Чухал	64	7.6%
	Бага зэрэг чухал	7	0.8%
6.3.6. Сурлагын амжилтад	Маш чухал	69	8.2%
	Чухал	67	8.0%
	Бага зэрэг чухал	7	0.8%
6.3.7. Номтой зөв харьцдаг болоход	Маш чухал	82	9.8%
	Чухал	61	7.3%